



ЖИЛИЙН ТАЙЛАН 2021

АГУУЛГА

1. Компанийн мэдээлэл	10
1.1. Алсын хараа, үнэт зүйлс	10
1.2. Компанийн ерөнхий танилцуулга	11
1.3. Компанийн бүтэц	11
1.4. Төлөөлөн удирдах зөвлөл болон Удирдлагын баг	12
2. Гүйцэтгэх удирдлагын тайлан.....	17
2.1. Санхүүгийн гүйцэтгэл	18
2.2. Стратегийн чиглэл болон гүйцэтгэл.....	24
2.3. Өрсөлдөөний орчин	28
2.4. Эрсдэлийн хүчин зүйлс ба удирдлага.....	30
3. Тогтвортой хөгжлийн тайлан	32
3.1. Байгаль орчин.....	32
3.2. Нийгэм	33
4. Компанийн засаглалын тайлан	36
4.1. Хувьцаа эзэмшигчид	36
4.2. Төлөөлөн удирдах зөвлөл.....	37
4.3. Эрсдэлийн удирдлага болон дотоод хяналт	40
5. Санхүүгийн тайлангууд	40
6. Хавсралт	44

Энэхүү хуудсыг зориудаар хоосон үлдээсэн болно.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ


Ам.доллар	Америкийн Нэгдсэн Улсын мөнгөн тэмдэгт
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
Вон	Бүгд Найрамдах Солонгос Улсын мөнгөн тэмдэгт
БЗД	Баянзүрх дүүрэг
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОНЗ	Байгаль орчин, нийгэм, засаглал
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МТШХХГ	Мэдээллийн Технологи, Шуудан, Харилцаа Холбооны Газар
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
СХД	Сонгинохайрхан дүүрэг
СЭЗИС	Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
ТББ	Төрийн бус байгууллага
Төгрөг	Монгол Улсын мөнгөн тэмдэгт
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБ	Улаанбаатар хот
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХК	Хувьцаат Компани
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТС	Шатахуун түгээх станц
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Юань	Бүгд Найрамдах Хятад Ард Улсын мөнгөн тэмдэгт
ЮНИСЕФ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сан

ИРЭЭДҮЙГ ЧИГЛЭСЭН МЭДЭГДЛИЙН ТАЛААРХ АНХААРУУЛГА

Сэнтрал Экспресс Си Ви ЭС ХК нь энэхүү 2021 оны үйл ажиллагааны тайланг нь 2021 онд батлагдсан Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу бэлтгэсэн бөгөөд энэхүү тайланд “ирээдүйг чиглэсэн” зарим мэдэгдэл агуулагдсан болно. Тухайлбал, тус тайланд “бид таамаглаж байна, бид тооцоолж байна, бид зорьж байна, бид төлөвлөж байна” гэх мэт үгстэй ойролцоо үг, мөн ирээдүй цагийг илэрхийлэх үгс ашиглагдсан. Ирээдүй рүү чиглэсэн мэдэгдэл нь ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлын баталгаа биш буюу ирээдүйд бидний таамагласан нөхцөл байдал биелэхгүй байх боломжтой бөгөөд тэдгээр таамаглалуудад хэт найдах нь учир дутагдалтайг анхаарна уу.

Компанийн бизнесийн үйл ажиллагааны цаашдын чиг хандлага нь тус тайлангийн “Гүйцэтгэх удирдлагын тайлан” бүлэгт тайлбарлагдсан эрсдэл, тодорхойгүй байдал гэх мэт хүчин зүйлс, мөн үүгээр хязгаарлагдахгүй зүйлсээс хамаарч материаллаг зөрүүтэй байж болно. Тиймээс, эдгээр эрсдэл болон тодорхойгүй байдлыг харгалзан үзэж ирээдүйг чиглэсэн мэдэгдэл, төсөөллийг яг тэр чигээр нь бодитоор биелнэ хэмээн авч үзэх нь өрөөсгөл юм. Мөн, компанийн зүгээс шинэ мэдээ мэдээлэл болон ирээдүйд гарах ялгаатай үр дүн эсвэл аливаа бусад шаардлагын улмаас энэхүү тайланд тусгагдсан ирээдүйд чиглэсэн таамаглалуудыг шинэчлэх эсвэл засварлах аливаа үүрэггүй болохыг мэдэгдэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ



Энэхүү хуудсыг зориудаар хоосон үлдээсэн болно.

Хөрөнгө оруулагч таны энэ өдрийн амгаланг айлтгая.

Миний бие та бүхэнтэй Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн нийт хамт олныг төлөөлөн 2021 оны сургамж болоод амжилт, ирээдүйд хүлээж буй сорилт хийгээд боломжийн талаар та бүхэнтэйгээ хуваалцаж буйдаа таатай байна.

Өнгөрсөн 2021 он бидний хувьд түүхэн жил байлаа. Та бүхний мэдэж байгаачлан өнгөрсөн гурван жилд бид бүгд олон бэрхшээлтэй тулгарсан ч тэр бүрийг хамтын зүтгэлээр даван гарч, үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн өмнө тавьсан олон нийтийн компани болох зорилгодоо хүрч чадсан. Олон нийтийн компани болсноор бид бүхэн хэдэн мянган хөрөнгө оруулагчдын өмнө хариуцлага хүлээж, компанийн хөгжлийн нэгэн шинэ үе эхэлсэн билээ. Компанийн ирээдүйд итгэл хүлээлгэсэн нийт хувьцаа эзэмшигч та бүхэнд талархаж буйгаа илэрхийлье.

Бид төлөвлөгөөнийхөө дагуу бизнесээ үргэлжлүүлэн өргөжүүлж, 2022 оны 4-р сарын байдлаар 200 дэлгүүртэй болж, өдөр бүр 80,000-аас дээш хүнд үйлчилж байна. Та бидний хамтдаа бүтээн байгуулж буй СИ сүлжээ нь их хотын иргэд өдөр, шөнийн аль ч цагт тав тухтай үйлчлүүлж эрч хүчээ цэнэглэдэг,

эрүүл цэвэр соёл, амралтын цэг болж чаджээ. Бид үйлчлүүлэгчдэд хамгийн ойр байрлаж, тэдний өдөр тутмын амьдралд үнэ цэн нэмэх тэмүүлэл дүүрэн байна.

Даяаршин буй дэлхий ертөнцөөс үүдэлтэй бэрхшээл, сорилт нэмэгдэж буй ч бидний цаашдын амжилт зөвхөн биднээс л хамаарах ёстой. Бид олон улсын жишиг болсон шинэлэг үйлчилгээг бизнестээ нэвтрүүлэхээс гадна эрүүл, чанартай хүнсний бүтээгдэхүүний тогтвортой нийлүүлэлтэд ач холбогдол өгч, үйлдвэрлэгчидтэйгээ хамтран ажиллах замаар хотын иргэдийн ахуй амьдралыг илүү хялбар, ая тухтай болгохыг эрхэм зорилго болгодог.

Бид цаашид зөвхөн дотоодын хэрэглэгчдэд шинэ үнэ цэн үүсгэхэд анхаараад зогсохгүй олон улсад 16 мянга гаруй салбартай СИ сүлжээг түшиглэн экспортлогч компаниудын бүтээгдэхүүнүүдийг олон улсын зах зээлд гаргаж, Монгол брэндийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийг эрмэлзэн ажиллаж байна.

Бид нийгэмд үнэ цэн бүтээх, энэхүү үнэ цэнээ оролцогч талуудтайгаа хуваалцах нь зах зээлд тогтвортой оршиж, өсөж хөгжихийн үндэс гэдгийг хөрөнгө оруулагч та бүхэндээ харуулах болно.

ХАМТЫН ҮНЭ ЦЭНЭЭ ӨСГӨЕ!

А. ГАНХУЯГ

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ



Хөрөнгө оруулагч таны энэ өдрийн амгаланг айлтгая.

Өнгөрсөн гуч гаруй жилд Монголчуудын амьдралын хэв маяг багагүй өөрчлөгджээ. Бидний өдөр тутмын амьдралын хэмнэл улам цаг завгүй, хурдтай болон өөрчлөгдсөөр байна. Ийм ч учраас бид өнөөдрийн Монголчуудын амьдралын хэв маягт тохирох үргэлж нээлттэй байдаг, хаанаас ч олж болох, чанартай бүтээгдэхүүн, соёлтой үйлчилгээтэй дэлхийн стандартын конвинеенс дэлгүүрийн сүлжээг Монголдоо байгуулах шийдвэрийг эдүгээгээс 4-н жилийн өмнө гаргаж, дэлхийн шилдэг брэндүүдийн нэг болох БНСУ-ын “CU” конвинеенс дэлгүүрийн мастер франчайзийн эрхийг авч 3 жил хагасын өмнө анхны CU дэлгүүрээ Улаанбаатар хотод нээж байлаа. Тэгвэл 2021 оны төгсгөлд бид 165 салбар дэлгүүртэй, өдөр бүр 60 мянган хүнд үйлчилдэг, Улаанбаатарчуудын өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг болон өргөжин тэлжээ.

2021 оны хамгийн онцлох зүйл бол бид Компанийн хувьцаагаа олон нийтэд нээлттэй санал болгож 9,500 гаруй хувьцаа эзэмшигчидтэй болсон үйл явдал байлаа. Ингэснээр бид манай хувьцааг эзэмшигч олон мянган хүнд урт хугацаанд тогтвортой үр өгөөжийг хүртээх боломжийг нээгээд байна.

2021 онд бид хувьцаагаа олон нийтэд санал болгохдоо Компанийнхаа хэтийн зорилго, санхүүгийн төлөвлөгөөг танилцуулсан. Корона вирусын өндөр тархалт, тээвэр логистикийн гацаа, үнийн өсөлт зэрэг олон хүндрэлтэй жил байсан хэдий ч бид хөрөнгө оруулагчдадаа амласандаа хүрч нийт 94 тэрбум төгрөгийн цэвэр борлуулалтын орлоготой ажиллаж төлөвлөгөөгөө 6.2 хувиар давуулан биелүүлсэн бөгөөд цэвэр алдагдал 18 тэрбум төгрөг буюу төлөвлөснөөс 2 тэрбум төгрөгөөр бага алдагдалтай ажиллалаа.

Бид аливаа бизнесийн амжилттай оршин тогтнох үндэс нь нийгэмдээ бүтээж буй үнэ цэнээр тодорхойлогддог гэдэгт итгэдэг. Тийм ч учраас бид үйлчлүүлэгчид, ажилчид, бэлтгэн нийлүүлэгчид, нийгэмд болон хөрөнгө оруулагчдадаа тогтвортой үнэ цэнийг бүтээн ажиллахыг эрмэлздэг.

CU дэлгүүрийн гол зорилго нь үйлчлүүлэгчийнхээ цагийг хэмнэх юм. 2021 онд CU дэлгүүрээс бэлтгэсэн хоол, зууш худалдан авсан үйлчлүүлэгчдийн давтагдсан тоо 6 саяыг давсан байна. Цайны газар, кафе, ресторанд хоол идэхэд нэг хүн дунджаар 50 минут зарцуулдаг гэсэн судалгаа байдаг. Харин CU дэлгүүрээс хоол авч идэхэд дунджаар 20 минутыг зарцуулдаг. Ингээд бодохоор 2021 оны туршид бид 6 сая үйлчлүүлэгчийнхээ 30 минут буюу нийт 3 сая хүн цагийг хэмнэсэн байна. Энэ нь ойролцоогоор нийт 12 тэрбум төгрөгтэй тэнцэх бодит хэмнэлт, үнэ цэнийг CU дэлгүүр үйлчлүүлэгчдэдээ бий болгосон байна. Дээрх 12 тэрбум төгрөг бол зөвхөн бэлтгэсэн хоол, зуушны үйлчилгээнээс бий болсон үнэ цэнэ бөгөөд 2021 онд манай үйлчлүүлэгчдийн 45 хувь нь бэлтгэсэн хоол зууш худалдан авсан байна.

Бид соёлтой, шуурхай үйлчилгээ, дэлхийн жишиг болсон бүтээгдэхүүн үйлчилгээгээр хэрэглэгчдийнхээ өдөр тутмын амьдралыг илүү хялбар болгож, бүх дэлгүүрээ инээмсэглэл, эелдэг харилцаагаар дүүргэхийг эрмэлздэг. Үүний тулд ажилтан албан хаагчдадаа дэлхийн жижиглэн худалдааны тэргүүний туршлага, ур чадварыг эзэмшүүлж, олон улсын шилэгдмэл нөү хауг эх орондоо нутагшуулж, жижиглэн худалдааны салбарыг шинэ түвшинд хүргэхээр ажиллаж байна.

2021 онд бид нийт 1,855 хүнийг ажлын байраар хангаж, нийт 16 орчим тэрбум төгрөгийн цалин урамшууллыг олгосон байна. Мөн давтагдсан тоогоор 2,465 ажилтандаа зориулж дэлхийн үйлчилгээний стандарт, хувь хүний хөгжлийн сургалтуудыг зохион байгуулсан.

Манай бизнесийн чухал оролцогч тал бол бэлтгэн нийлүүлэгч юм. 2021 оны туршид бид нийт 500 гаруй дотоодын бэлтгэн нийлүүлэгчээс 71 орчим тэрбум төгрөгтэй тэнцэх бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авсан. Бэлтгэн нийлүүлэгчдийн цэвэр ашгийн маржиныг дунджаар 10 хувь гэж таамаглавал бид нийт 500 гаруй дотоодын аж ахуйн нэгжүүдэд 7 тэрбум төгрөгийн цэвэр ашиг, үнэ цэнийг бий болгосон байна.

Бид дэлгүүрийн сүлжээгээ зөвхөн шуурхай, соёлтой үйлчилгээний цэг биш, орчин тойрондох иргэдийн өдөр тутмын амьдралын түшиг тулгуур, нийгмийн дэд бүтэц болгон хөгжүүлэхийг зорьдог. Өнөөдөр бид нийтийн ариун цэврийн өрөөгөөр үнэ төлбөргүй үйлчлүүлэх, аюул осол тохиолдсон үед аюулгүй байдлаа хангуулах, халуун хүйтэнд амсхийх цэг зэрэг боломжуудыг олон нийтэд санал болгож, авто замын ачаалал багатай цагуудаар барааны түгээлтээ зохион байгуулж Улаанбаатар хотын түгжрэл, агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулж байна. 2021 оны 12-р сарын байдлаар CU-ийн нийт 165 салбар дэлгүүрт өдөрт дунджаар 28,000 хүн нийтийн ариун цэврийн өрөөгөөр үнэ төлбөргүй үйлчлүүлж байгаа нь Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээний дэд бүтцийг сайжруулах, орчны бохирдлыг бууруулах, хотын ая тухыг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр үзүүлж байна гэж итгэдэг.

2021 оны 3, 4-р улиралд эдийн засаг эрчимтэй сэргэж, худалдаа үйлчилгээний бизнесийн үйл ажиллагаа явуулах боломж нэмэгдсэн нь бидний бизнест чухал дэмжлэг үзүүлсэн бөгөөд 2022 онд худалдаа үйлчилгээ эрхлэх орчин илүү нээлттэй, тааламжтай болж байна. Иймд, бид 2022 оныг өөдрөг төсөөлөлтэй харж байгаа ба хувьцаа эзэмшигчдийнхээ хүлээлтэд хүрэхийн тулд Компанийн бүх ажилчид өдөр бүр хичээнгүйлэн ажиллаж байгааг энд дурдах нь зүйтэй.

Олон жилийн турш тогтвортойгоор үнэ цэн нь өсөх Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн хувьцаа эзэмшигч болсон та бүхэнд миний бие туйлын талархаж байгаа бөгөөд та бүхэнтэй хамт Монгол Улсын хөгжилд хувь нэмрээ оруулж чадна гэдэгт бүрэн итгэж байна.

CU-д ТАВТАЙ МОРИЛ!

Г.Чинзориг

Гүйцэтгэх захирал

1. Компанийн мэдээлэл

1.1. Алсын хараа, үнэт зүйлс

<p>Алсын хараа</p> <p>Хэрэглэгчийн үйлчилгээгээрээ дэлхийд танигдана.</p>	<p>Эрхэм зорилго</p> <p>Үйлчлүүлэгчдэдээ орлуулшгүй үнэ цэнийг өдөр бүр өгнө.</p>
--	--

Бидний үнэт зүйлс

Чухал зүйлд төвлөрдөг: Гол том зорилгоо мэддэг, том дүр зургаар харж түүнийхээ дагуу ажлуудаа зөв эрэмбэлж чухал ажлуудаа ялгаж таньдаг.



Нийтийн төлөө: Хамтарч ажиллагсдадаа тусалснаар бид амжилтад хүрнэ. Асуух, сонсох, ойлгохыг хичээх арга барилаар бусадтай харилцдаг байх.

Зоригтой: Өөрийн таатай бүсээс гарч зоригтой алхам хийж өөрийгөө хөгжүүлдэг. Өөрийнхөө лимит буюу хязгаарыг тодорхойлдоггүй, өөрийгөө хамгаалсан зан хандлага гаргадаггүй.



Хувь хүний үнэт зүйлийг бус асуудлыг шүүмжилдэг: Гаргасан алдаагаа давтдаггүй, алдаанаасаа суралцагч байдаг. Гарсан алдаатай холбоо бүхий л үйл явц, асуудал, шалтгааныг нээлттэй хэлэлцэж, бодитоор шүүмжилдэг.

Нээлттэй сэтгэдэг: Бусдын саналыг сонсох, цаг зарцуулдаг байх. Ярихаасаа илүү сонсдог, бусдын үзэл бодлоо хэлэхийг дэмждэг.



Шулуун шударга: Мэргэжлийн байр сууринаас асуудалд ханддаг. Зөв гэж бодсон зүйл дээрээ нээлттэй мэтгэлцдэг.



Тууштай: Өөрийн ажиллаж буй салбартаа чин сэтгэлээсээ дуртай, сонирхолтой, хүсэл эрмэлзэлтэй. Үр дүнд хүрэхийн тулд аливаа зүйлд тэвчээр хатуужилтай тууштай хандаж алхам алхмаар сайжруулдаг

1.2. Компанийн ерөнхий танилцуулга

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК ("Компани") нь Монгол Улсын жижиглэн худалдаа болон конвинеенс дэлгүүрийн зах зээлд тэргүүлэгч компани бөгөөд 2018 онд CU олон улсын конвинеенс сүлжээ дэлгүүрийг Монгол Улсын жижиглэн худалдааны салбарт нэвтрүүлэх Мастер франчайзийн гэрээг БНСУ-ын БиЖиЭф Ритэйл Ко., Лтд (BGF Retail Co., Ltd.) компанитай амжилттай байгуулж Улаанбаатар хотод 6 сүлжээ дэлгүүртэйгээр үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Компани нь Монголын хөрөнгийн бирж ("МХБ")-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани ба "CUMN" тэмдэгтээр хувьцаа нь олон нийтэд нээлттэй арилжаалагдаж байна.

Конвинеенс сүлжээ дэлгүүр нь хэрэглэгчийн хамгийн ойр байршилд, хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлчилгээг бүх цагт нээлттэйгээр тасралтгүй хангаж ажилладаг онцлогтой.



CU конвинеенс сүлжээ дэлгүүр 2021 оны эцэст Улаанбаатар хотод 165 салбар дэлгүүртэй болж үйл ажиллагаагаа улам тэлсээр байна. Премиум Дистрибьюшн ХХК нь конвинеенс сүлжээ дэлгүүрийг өдөр бүр шинэ бараа бүтээгдэхүүнээр найдвартай хангах зорилгоор түгээлтийн иж бүрэн үйлчилгээ, хоол үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Компанийн нэр: Сэнтрал Экспресс Си Ви Эс хувьцаат компани

Үйл ажиллагааны чиглэл: Хүнсний дэлгүүр, хүнсний үйлдвэрлэл, худалдааны зуучлал, франчайзийн гэрээний үндсэн дээр бизнесийн үйл ажиллагаа явуулах, гадаад худалдаа, менежментийн зөвлөх үйлчилгээ

Компанийн албан ёсны хаяг: Монгол Улс, Улаанбаатар 14220, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж 31, Далай Туур 11-н давхар

Холбоо барих:

+976-77330101

info@cumongol.mn, hr@cumongol.mn

www.cumongol.mn

Үүсгэн байгуулагдсан огноо:

2017 он 02-р сарын 20


Ажилчдын тоо:

1,855

Дэлгүүрийн тоо:

165

1.3. Компанийн бүтэц



2022 оны 3-р сард компанийн үйл ажиллагааны бүтцийг илүү тодорхой болгох зорилгоор Сэнтрал Коммерс ХХК-ийг байгуулсан.

1.4. Төлөөлөн удирдах зөвлөл болон Удирдлагын баг

Төлөөлөн удирдах зөвлөл

Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь компанийн бүх оролцогч талуудад, ялангуяа хувьцаа эзэмшигчдэд урт хугацааны үнэ цэнийг бий болгох зорилгоор бизнесийн стратеги, үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлогыг тодорхойлох, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлэх, үр дүнд хяналт тавих, дотоод хяналтын оновчтой тогтолцоог бий болгох зорилготойгоор ажилладаг. ТУЗ нь дараах 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.



Адилбишийн Ганхуяг нь Премиум Групп ХХК-ийн үүсгэн байгуулагч, Премиум Групп ХХК болон Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн дарга, Нэр дэвшүүлэх хорооны дарга, Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын Ерөнхийлөгч бөгөөд сүүлийн 20 гаруй жил Монголын нэр нөлөө бүхий томоохон компаниуд болох М-Си-Эс Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, М-Си-Эс Кока-Кола ХХК болон Юнител ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Монголиан Майнинг Корпорацийн (НКЕХ: 975)-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү эрхэлсэн дэд ерөнхийлөгчөөр ажиллаж ирсэн туршлагатай. Тэрээр эдгээр компаниудын үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, таниулахад үнэтэй хувь нэмэр оруулж, эрчим хүч, уул уурхай, хөнгөн үйлдвэр, дэд бүтэц, барилга, худалдааны салбарт томоохон хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт татах ажлыг амжилттай удирдан зохион байгуулсан. А.Ганхуяг нь Монгол Улсын Их Сургууль (“МУИС”)-ийг санхүү, эдийн засгийн бакалаврын зэрэгтэй төгссөн.



Адилбишийн Ганболд нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Цалин урамшууллын хорооны дарга бөгөөд Премиум Групп ХХК-ийн үүсгэн байгуулагч, ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирлын албан тушаалыг хашдаг. Түүний туршлагыг дурдвал, Монгол Улсын авто зам барилга, хотын дэд бүтцийн компани болох Нэйшнл Девелопер ХХК-ийн Гүйцэтгэх захирал, тансаг зэрэглэлийн тавилга үйлдвэрлэгч Ганброс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд Ерөнхий захирлаар ажиллаж байсан. Тэрээр Оросын Холбооны Улсын Харьков хотын Барилгын дээд сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль (“ШУТИС”)-ийг цахилгаан тээвэр, системийн инженер мэргэжлээр суралцсан, бакалаврын зэрэгтэй.



Гансүхийн Бат-Эрдэнэ нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны гишүүн, Премиум Групп ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү хариуцсан дэд ерөнхийлөгч бөгөөд тус группийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлийн удирдлагын тогтолцоог хариуцан ажилладаг. Тэрээр анхны ажлын гараагаа үйлдвэрлэл, худалдааны салбарт тэргүүлэгч М-Си-Эс Кока Кола ХХК-д санхүү төлөвлөлтийн газрын даргаар эхлүүлсэн. Сүүлийн 18 жилийн хугацаанд өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, уул уурхай, эрчим хүч, аж үйлдвэрлэл, барилгын салбарт ажиллаж, Монголиан Майнинг Корпорац (НКЕХ: 975) болон Премиум Групп ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан бөгөөд М-Си-Эс Энержи ХХК-ийн дэд захирал, Монголиан Майнинг Корпорацийн Санхүү хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай. Г.Бат-Эрдэнэ нь Хан-Уул Дээд Сургуулийг бизнесийн удирдлага, хэрэглээний математикч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.



Очирбатын Батмөнх нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Байгаль орчин, нийгэм, засаглалын хорооны гишүүн, Премиум Групп ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Дэд ерөнхийлөгч, Премиум Конкрит ХХК-ийн Гүйцэтгэх захирал бөгөөд тус группийн уул уурхай, барилга, бетон зуурмагийн бизнесийг хариуцан ажилладаг. Тэрээр Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал (NUBIA), Шангри-Ла зочид буудал цогцолбор төсөл, Салхит (50 МВт), Сайншанд (55 МВт), Цогтцэций (50 МВт) зэрэг салхин цахилгаан станцын төслүүд, Оюу толгой Бетон зуурмагийн 4 дүгээр үйлдвэрийн цогцолбор болон бутлуурын үйлдвэрүүдийн зураг төсөл, барилга, үйл ажиллагааг хариуцах зэргээр томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн, бизнесийн удирдлагын чиглэлээр 15 жил ажилласан туршлагатай. Тэрээр АНУ-ын Үндэсний Их Сургуулийг компьютерын шинжлэх ухааны бакалавр, бизнесийн удирдлагын магистр зэрэгтэйгээр төгссөн.



Болдбаатарын Бат-Эрдэнэ нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Байгаль орчин, нийгэм, засаглалын хорооны гишүүн, Польшийн Хөгжлийн Сангийн Хөрөнгө Оруулалт Худалдааны Агентлагийн Монгол дахь суурин төлөөлөгч, Хорайзон Партнерс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаа, худалдааны чиглэлээр 12 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр Польш, АНУ, Швейцар улсад сурч, Монголын анхны гадаадын (Японы) хөрөнгө оруулалтын банкинд зах зээлийн шинжээчээр, Олон Улсын Санхүүгийн Корпорац болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалттай Монголын анхны хаалттай хөрөнгө оруулалтын санд (50 сая ам. долларын) зах зээл, бизнесийн шинжээчээр, Польш-Монголын хамтарсан худалдааны компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан ба Азийн Хөгжлийн Банкны Монгол улсад “Private Equity” болон “Venture Capital” хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийг хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх компаниар ажилласан хөрөнгө оруулалт, стратеги, менежментийн зөвлөх үйлчилгээний компанийн үүсгэн байгуулагч юм. Б.Бат-Эрдэнэ нь Санхүү Эдийн Засгийн Их Сургууль (“СЭЗИС”)-ийг нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэйгээр төгссөн.



Ганболдын Чинзориг нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал юм. Тэрээр программ хангамж, бизнес процесс, бизнес интеллиженс, мэдээллийн технологийн мастер төлөвлөлт, инженерчлэлийн чиглэлээр ажилласан туршлагатай бөгөөд Мэдээллийн Технологи, Шуудан, Харилцаа Холбооны Газар (“МТШХХГ”)-ын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагт Эдийн засгийн бодлогын шинэчлэл ба өрсөлдөх чадварын төслийн мэдээллийн технологийн зөвлөх, Азийн Хөгжлийн Банкны Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төсөл, Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн систем ба санхүүгийн дэд бүтцийн зөвлөхөөр тус тус ажиллаж байсан туршлагатай. Тэрээр МТШХХГ-т ажиллаж байхдаа Цахим засаглал хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, Монгол Улсын Харилцаа холбоо, интернэт, шуудан, хэвлэл мэдээлэл, хиймэл дагуулын холбооны талаар баримтлах төрийн бодлого болон Мобайл сүлжээний 4G үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх зохицуулалтын бодлогыг боловсруулсан. Г.Чинзориг нь ШУТИС-ийг компьютерын шинжлэх ухааны бакалавр, АНУ-ын Луисвиллийн Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.



Нямжавын Энхболд нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хорооны гишүүн бөгөөд 2016 оноос Ньюком Группийн Гүйцэтгэх захирлаар, мөн 2017 оноос 2022 оныг хүртэл ТУЗ-ийн даргаар ажиллаж байсан. Тэрээр хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлага, санхүү, төсөл боловсруулалт, корпорацын стратеги, бизнес хөгжил, үйл ажиллагаа зэрэг Ньюком Группийн бүхий л салбар нэгжид идэвхтэй үүрэг гүйцэтгэн ажилласан бөгөөд тус группийн хөрөнгө оруулалттай компаниудын Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар мөн ажиллаж байсан. Н.Энхболд нь М-Си-Эс Группийн стратеги, бизнес хөгжил хариуцсан дэд захирал, группийн бусад компаниудад гүйцэтгэх удирдлагаар 17 жил ажиллахдаа мэдээллийн технологи, харилцаа холбоо, санхүү, үл хөдлөх хөрөнгө зэрэг олон салбарт ажилласан туршлагатай. Н.Энхболд нь Нидерландын Маастрихтын Удирдлагын Сургуулийг корпорацын стратеги, бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй, МУИС-ийг электроникийн инженер, бакалаврын зэрэгтэй төгссөн.



Чулууны Мэргэн нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн бөгөөд Exponential Partners, Тогтох Трейд ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Пропрети Лаб ХХК-ийн хөрөнгө оруулагч, дэлхийн хамгийн том хурдасгуур хөтөлбөрийн нэг болох Founder Institute-н Монгол дах төлөөлөгч, олон улсын STS Capital International M&A Firm-ийн Ахлах зөвлөх, International Deal Gateway байгууллагын Азийн итгэмжит төлөөлөгч, 140 орны 30,000 гүйцэтгэх захирлуудыг хамруулсан УРО байгууллагын гишүүн мөн Entrepreneurship & Innovation Network-ийн ТУЗ-ийн гишүүн юм. Тэрээр 2007 оноос хойш бизнесийг томруулах, өсөлтийн менежментийн систем, хувь хүний хөгжил, технологи, инновацын чиглэлээр гарааны бизнес болон Монголын шилдэг компаниуд болох Вагнер Ази ХХК, Монголын Бизнесийн Зөвлөл, Монголын хамгийн анхны интернэт маркетингийн агентлаг Вэбгүрү байгууллагын захирал, Ерөнхий сайдын Эдийн засгийн бодлогын зөвлөлийн гишүүнээр ажилласан туршлагатай. Ч.Мэргэн нь Колорадо Мужийн Их Сургуульд мэдээллийн систем, санхүүгийн менежмент, энтрепренершип чиглэлээр тус тус суралцсан бөгөөд Харвардын Бизнесийн Сургуульд Ерөнхийлөгчдийн хөтөлбөрт хамрагдаж байсан.



Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн, Байгаль орчин, нийгэм, засаглалын хорооны дарга, Цалин урамшууллын хороо, болон Аудитын хорооны гишүүн, Улаанбаатар дахь Олон Улсын Дунд Сургуулийн ТУЗ-ийн дарга, Жуулчин Уорлд Турс ХХК-ийн ахлах зөвлөх, Эдельвайс Арт зочид буудлын гүйцэтгэх захирал бөгөөд Монгол дахь Америкийн худалдааны танхим (АмЧам Монгол)-ын ТУЗ-ийн дэд даргаар ажиллаж байсан. Тэрээр 30 гаруй жил зочид буудлын менежментийн салбарт, тэр дундаа ажилчдын сургалтын хөтөлбөр, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт, чанар, дотоод хяналтын удирдлага, галын аюул, осол үүсэх эрсдэлийн удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлж, хяналт тавьж ажилласан туршлагатай. Гари Биондо нь Азийн өөр өөр соёл иргэншилтэй олон улс орнуудад өндөр зэрэглэлийн Шангри-Ла олон улсын зочид буудал, резортод 28 жил ерөнхий менежер, гүйцэтгэх удирдлагаар ажилласан бөгөөд АНУ-ын Колорадо мужийн Колорадо Коллежийг сонгодог уран зохиол, гүн ухааны чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.

Удирдлагын бүтэц

Компанийн удирдлагын бүтэц зохион байгуулалтын хувьд Гүйцэтгэх захирлын шууд удирдлага доор Дэлгүүр хөгжүүлэлтийн газар, Борлуулалт үйлчилгээний газар, Ханган нийлүүлэлтийн газар, Мерчиндайзингийн газар, Маркетингийн газар, Мэдээллийн технологийн газар, Санхүүгийн газар, Захиргаа, хүний нөөцийн газар, Эрсдэлийг бууруулах газрууд үйл ажиллагаа явуулдаг.

Компанийн удирдлагын бүтэц



Удирдлагын багийн танилцуулга

Чогсомын Сараа нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Мерчиндайзингийн газрын захирал бөгөөд Эрин Системс ХХК, Зам Тээврийн Хөгжлийн Яам, Иргэний Нисэхийн Ерөнхий Газар, Хүмүүнлэгийн Их Сургууль зэрэг боловсрол, нисэх, технологи, жижиглэн худалдааны салбарт нийт 12 жил ажилласан туршлагатай. Тэрээр Австралийн Сидней Их Сургуулийг худалдааны магистр зэрэгтэй төгссөн.

Батмөнхийн Цэвэлмаа нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Ханган нийлүүлэлтийн газрын захирал бөгөөд Монголын Монголиан Майнинг Корпорац (НКЕХ: 975)-д Уул Уурхайн Корпорацад Логистикийн менежерээр ажлын гараагаа эхлүүлж, Монос Фарм Трейд ХХК-ийн Ханган нийлүүлэлтийн төслийн ахлах менежер, Премиум Групп-д Логистикийн менежерээр ажилласан бөгөөд ханган нийлүүлэлт, үйл ажиллагааны чиглэлээр 14 жил ажилласан туршлагатай. Тэрээр ШУТИС-ийг үйлдвэрлэлийн автоматжуулалтын инженер мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.

Ганчимэгийн Батбаатар нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Маркетингийн газрын захирал бөгөөд М-Си-Эс Групп, Голомт Банк, Вагнер Ази, Шангри-Ла Улаанбаатар зэрэг Монголын томоохон компаниудад маркетингийн чиглэлээр 10 гаруй жил ажилласан. Тэрээр АНУ-ын Роквиллын их сургуулийг Мэдээллийн технологи тэр дундаа Шийдвэр дэмжих систем (DSS)-ийн чиглэлээр төгссөн бөгөөд боловсрол, эрүүл мэнд, онлайн худалдаа болон үл хөдлөхийн чиглэлээр олон төрлийн дижитал платформуудын төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай.

Төрболь-ийн Билгүүн нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Мэдээллийн технологийн газрын захирал бөгөөд Мобиком Корпорацад софтвер архитектур, Япон улсын Никкэй телеком 21 компанид Системийн инженер, Рио Тинто Монголд Өгөгдлийн шинжээчээр тус тус ажиллаж байсан ба давхар технологийн стартап компаниудыг үүсгэн байгуулж, амжилттайгаар удирдаж байна. Тэрээр салбартаа нийт 12 жил ажилласан туршлагатай. Т.Билгүүн нь Нью-Йорк-ийн Их Сургуулийг өгөгдлийн шинжлэх ухааны магистр зэрэгтэй төгссөн.

Ганзоригийн Гэрэлт-Од нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Дэлгүүр хөгжүүлэлтийн газрын захирал бөгөөд банкны салбараас ажлын гараагаа эхэлж, Чингис хаан банкны Худалдааны санхүүжилтийн мэргэжилтэн болон Байгууллагын банкны зээлийн эдийн засагчаар 5 жил ажиллаж, Компанид 2017 оноос хойш ажиллан Бизнес хөгжлийн менежер, Категори менежер, Дэлгүүр төлөвлөлтийн албаны дарга албан тушаалд тус тус ажиллан, банк санхүү, худалдааны салбарын 10 жилийн туршлагатай. Г.Гэрэлт-Од нь АНУ-ын Си Си Си коллежийг бизнесийн удирдлага болон нягтлан бодогчоор хавсран төгсөж, Англи улсын Глостерширийн их сургуулийг бизнесийн удирдлага, санхүүгийн чиглэлээр магистрын зэрэгтэй төгссөн.

Дашжавын Нямсүрэн нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Борлуулалт, үйлчилгээний газрын захирал бөгөөд Таван Богд групп, Нарантуул зочид буудал, Нано Интернэйшнл зэрэг компаниудад худалдааны чиглэлээр 18 жил ажилласан туршлагатай. Тэрээр дэлхийн зах зээлд танигдсан 40 гаруй брэнд бүтээгдэхүүнийг Монголын зах зээлд импортоор оруулж иржээ. Д.Нямсүрэн нь Сингапурын Стаффордширын Их Сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр зэрэгтэй төгссөн.

Ганзоригийн Сарангэрэл нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Захиргаа, хүний нөөцийн газрын захирал бөгөөд Мобиком Корпорацын Монгол Контент ХХК-д Хүний нөөцийн хэлтсийн дарга, 7 жил Таван Богд Фүүдс компанийн Хүний нөөцийн хэлтсийн дарга, Гоёо ХХК-ийн Дотоодын борлуулалтын захирлаар 1 жил ажилласан туршлагатай. Тэрээр Удирдлагын академийг бизнесийн удирдлагын дипломтой төгссөн.

Соронзоннайгалын Дашдорж, CFA нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Санхүүгийн газрын захирал бөгөөд СЭЗИС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхимд 8 жил ажилласан академик туршлагатай. Тэрээр Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлын менежментийн концессын гэрээг Японы консорциумтай байгуулах хэлэлцээрт Монгол улсын Зам Тээвэр, Хөгжлийн Яам, ИНЕГТ санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан. 2019 онд Премиум Групп-д Хөрөнгө оруулалтын менежерээр ажиллаж эхэлсэн бөгөөд академик, практик хослуулсан 10 гаруй жилийн ажлын туршлагатай. С.Дашдорж нь МУИС, СЭЗДС-ийг эдийн засгийн онолын магистр зэрэгтэй төгссөн, мөн олон улсын итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээчийн CFA цолтой.

Тогтохбаярын Молор нь Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн Эрсдэлийг бууруулах газрын захирал бөгөөд Таван Богд Трэйд ХХК-д Гадаад харилцааны мэргэжилтэн, Бизнес хөгжүүлэлтийн мэргэжилтэн, Таван Богд Фүүдс Пицца ХХК-д Чанарын албаны дарга, Үйл ажиллагааны албаны дарга, Таван Богд Фүүдс Пицца ХХК болон Таван Богд Хот Пот ХХК-д Ерөнхий менежерээр ажилласан 10 гаруй жилийн ажлын туршлагатай. Тэрээр ШУТИС-ийг аялал жуулчлалын менежмент, Түгээмэл дээд сургуулийг орчуулагчийн бакалавр зэрэгтэй төгссөн.



2. Гүйцэтгэх удирдлагын тайлан

Бид бизнесийн үнэ цэн, урт хугацааны амжилтад хөтлөгч гол үзүүлэлтүүдийг тодорхойлж, тэдгээрийг бодитой хэмжих, цаашлаад түүнд суурилсан оновчтой удирдлагын үйл ажиллагааг зохион байгуулахыг зорин ажилладаг. Тухайлбал, Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийн урт хугацааны өсөлт нь дэлгүүрийн дундаж борлуулалтын орлого, дэлгүүрийн тэлэлтийн тооноос шууд хамааралтай бөгөөд харьцуулагдахуйц дэлгүүрийн борлуулалт, нийт сүлжээний борлуулалт, үйл ажиллагааны мөнгөн урсгал зэрэг үзүүлэлтүүд нь бизнесийн өсөлт, үйл ажиллагааны стратегийн үр нөлөөг бодитоор үнэлэх, үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлийг тодорхойлоход ашиглагддаг нэн чухал ач холбогдолтой үзүүлэлтүүд байдаг тул Компанийн менежментийн баг эдгээр үзүүлэлтүүдийг тогтмол хянаж, хэмжиж байдаг. Иймд Компанийн 2021 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийг эдгээр чухал үзүүлэлтүүдээр хэмжин энэхүү тайлангаа бэлтгэн хүргэснээр хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад хамгийн чухал мэдээлэл болно гэдэгт итгэлтэй байна.

- **Харьцуулагдахуйц дэлгүүр** гэдэг нь харьцуулагдаж буй хоёр хугацаанд хоёуланд нь үйл ажиллагаа явуулж байсан дэлгүүр юм. Харьцуулагдахуйц дэлгүүрүүдийн тухайн жилийн борлуулалтыг өмнөх хугацааны борлуулалттай харьцуулах замаар бизнесийн гүйцэтгэлийг хэмжих нь чухал ач холбогдолтой. Борлуулалт нь хэрэглэгчдийн тоо болон сагсны дундаж үнээс шалтгаалдаг бөгөөд үүнд дэлгүүрээр үйлчлүүлэгчдийн тоо, бараа, бүтээгдэхүүний сонголт, мөн сагс дах бүтээгдэхүүний үнэ нөлөөлдөг.
- **Нийт сүлжээний борлуулалтад** Компани эсвэл франчайз эзэмшигчдийн ажиллуулдаг бүх сүлжээ дэлгүүрийн борлуулалтыг авч үздэг. Франчайз дэлгүүрийн борлуулалтын орлого нь Компанийн орлого хүлээн зөвшөөрөлтөд шууд хамаардаггүй ч сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагааны гүйцэтгэл, брэндийн үнэ цэнийг илэрхийлэх чухал үзүүлэлт юм. Франчайз дэлгүүрийн борлуулалт нь франчайз эзэмшигчдийн орлогын үндэс суурь бөгөөд франчайз эзэмшигчийн санхүүгийн тогтвортой байдлыг уг үзүүлэлт тодорхойлдог. Системийн хэмжээний борлуулалтын өөрчлөлт нь нэг дэлгүүрийн дундаж борлуулалт болон дэлгүүрийн тооноос шалтгаалдаг.
- **Үйл ажиллагааны мөнгөн урсгал** нь Компанийн бизнесийн үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого, үүнтэй шууд холбоотой гарсан мөнгөн зардал болон эргэлтийн цэвэр хөрөнгөөс хамаарч өөрчлөгддөг.

2.1. Санхүүгийн гүйцэтгэл

2021 оны санхүүгийн гүйцэтгэл

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь 2021 оны санхүүгийн төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн нь СИ брэндийн өсөлт хөгжил, мөн бизнесийн ба хувьцааны үнэ цэний тогтвортой байдлыг илтгэж байна.

Өнгөрсөн 2021 онд бид СИ сүлжээ дэлгүүрийн тоог 63-р нэмэгдүүлж, оны эцэст 165-д хүргэсэн бөгөөд Ковид-19 цар тахлын нөхцөл байдал сайжирч хөл хорио буурснаар цэвэр борлуулалтын орлогын хэмжээ 2020 онтой харьцуулахад 107.4 хувиар өсөж, 94.0 тэрбум төгрөгт хүрсэн.

Компанийн харьцуулагдахуйц дэлгүүрийн борлуулалтын хэмжээ 2020 онд өмнөх оноос 30.4 хувиар буурч байсан бол 2021 онд 39.9 хувиар өссөн байна. 2019 онтой харьцуулахад 2021 оны харьцуулагдахуйц дэлгүүрийн борлуулалтын хэмжээ 8.9 хувиар бага байна. Үүний нэг шалтгаан нь 2021 онд нэг дэлгүүрийн ажилласан цаг өдөрт дунджаар 16 орчим байсан нь 2019 оны үетэй харьцуулахад 30 орчим хувиар бага үзүүлэлт юм.


Компанийн дунд хугацааны төлөвлөгөөний дагуу сүлжээ дэлгүүрийн тоог нэмэгдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг 2021 оны 11-р сард Компанийн хувьцааг олон нийтэд санал болгох байдлаар (IPO) амжилттай татан төвлөрүүлж чадсан нь бизнесийн богино, дунд, цаашлаад урт

хугацааны үр дүнд томоохон эерэг нөлөөг үзүүлэх үйл явдал болсон юм.

Ковид-19 цар тахлын үр дагаврууд болох БНХАУ-ын хил хаагдсан, мөн нийлүүлэлтийн сүлжээний доголдоос үүдэлтэй логикийн асуудлын улмаас бид 185 салбар дэлгүүртэй болох төлөвлөгөөндөө хараахан хүрч чадаагүй ч 2021 оны 12-р сард Сиркл Чейн ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулснаар "Circle K" сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагаа явуулж буй 12 салбар дэлгүүрийг СИ сүлжээ дэлгүүр болгон хувиргах хэлцлийг амжилттай хийж чадсан юм. Уг хэлцлийн дагуу 2022 оны 1-р улиралд 12 дэлгүүрийг СИ сүлжээ дэлгүүр болгон үйл ажиллагааг эхлүүлсэн. Бид он гарснаар 2022 оны 3-р сарын 31-ний өдөр гэхэд 197 дэлгүүртэй болж дэлгүүрийн тэлэлт амжилттай үргэлжилсээр байна.

Нийлүүлэлтийн сүлжээний доголдоос үүдэлтэй логикийн хүндрэлүүд нь геополитикийн асуудлаас үүдэж улам том эрсдэл, сорилтыг үүсгэж байна. Удирдлагын багийн зүгээс эдгээр богино, дунд хугацааны хүндрэл, бэрхшээлийг даван туулахад гол анхаарлаа хандуулж байгаа бөгөөд, Компанийн бизнесийн дунд, урт хугацааны амжилт, ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхгүй гэдэгт итгэлтэй байна. Эдгээр асуудлаас сэргийлэхийн тулд Компани борлуулалтын төлөвлөгөөг сайтар тооцоолох, бараа материал татан авалтыг оновчтой зохион байгуулах, шаардлагатай нөөцийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авч байна.

Харьцуулагдахуйц дэлгүүрийн борлуулалтын индекс



Орлогын дэлгэрэнгүй тайлан, тэрбум төгрөгөөр

	2021	2020	Ж/ж%
Цэвэр борлуулалтын орлого	94.0	45.3	+107 %
Борлуулалтын өртөг	(100.9)	(50.7)	-99 %
Нийт ашиг, алдагдал	(6.9)	(5.4)	-28 %
Нийт ашгийн маржин хувь	-7.3 %	-11.8 %	+38 %
Ерөнхий, захиргааны болон борлуулалтын зардал	(7.9)	(5.1)	-54 %
Бусад орлого, зардал	0.9	(0.0)	+2894 %
Үйл ажиллагааны ашиг, алдагдал	(13.8)	(10.5)	-31 %
Санхүүгийн орлого	1.4	0.2	+797 %
Санхүүгийн зардал	(5.7)	(5.6)	-2 %
Татварын өмнөх ашиг, алдагдал	(18.1)	(15.9)	-13 %
Орлогын албан татварын зардал	(0.0)	0.2	-106 %
Татварын дараах ашиг, алдагдал	(18.1)	(15.7)	-15 %
Нэгж хувьцаанд ногдох ашиг, алдагдал	-37.8	-91.7	+59 %

Орлого, ашгийн гүйцэтгэл

Уг хэсэгт бид 2021 болон 2020 оны орлого, үр дүнгийн гүйцэтгэлийг харьцууллаа. 2020 он ба түүнээс өмнөх жилүүдийн гүйцэтгэлийг бид Үнэт цаасны танилцуулгын 2.6 хэсэгт тусгасан.

Үйлчлүүлэгчийн тооны бууралт, түүнээс шууд хамаарах өдрийн дундаж борлуулалтын бууралт юм. 2021 онд энгийн хувьцааны тоо өссөн учраас, нэгж хувьцаанд ногдох алдагдал 58.8 хувиар буурч 37.8 төгрөг болжээ.

Татварын өмнөх алдагдал болон нэгж хувьцаанд ногдох цэвэр алдагдал

Оны дунд үед 127 дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулсан 2021 оны хувьд татварын өмнөх цэвэр алдагдал нь өмнөх оноос 15 хувиар өсөж 18.1 тэрбум төгрөгт хүрсэн нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан санхүүгийн төлөвлөгөөнөөс 10 хувиар сайн гүйцэтгэл юм. Өмнөх 2020 оны дунд үед 80 дэлгүүртэй байсан ба уг жилийн алдагдал нь 15.9 тэрбум төгрөг байжээ. Өөрөөр хэлбэл, 2021 оны дэлгүүрийн тоо нь оны дунджаар тооцоход 2020 оноос 1.5 дахин өссөн хэдий ч, татварын өмнөх алдагдал нь 2020 онтой харьцуулахад 1.15 дахин өндөр байгаа юм. Энэ нь 2021 оны хувьд нэгж дэлгүүрийн гүйцэтгэл 2020 онтой харьцуулахад сайжирсныг илтгэнэ.

Борлуулалтын орлого

Компанийн борлуулалтын орлого нь бараа бүтээгдэхүүний орлого болон франчайз эрх эзэмшигчдэд үзүүлэх үйлчилгээний орлогоос бүрдэнэ. Үйлчилгээний орлогод франчайз эрх эзэмшигчийн борлуулалтын хувиар бодогдох роялтигийн орлого, бохир ашгаас тооцогдох менежментийн үйлчилгээний орлого, эд хөрөнгө түрээсийн орлого болон франчайзын эрх олгосон анхны хураамжийн төлбөрөөс орлого хүлээн зөвшөөрөлт зэрэг багтдаг.

Санхүүгийн тайлангийн 2020, 2021 оны санхүүгийн үзүүлэлтэд нөлөөлсөн цаашид дахин давтагдахгүй хүчин зүйл нь Ковид-19 цар тахлаас үүдэлтэй хөл хорио, цагийн хязгаараас хамаарсан

Цар тахалтай холбоотой хатуу хөл хорио, цагийн хязгаарлалт, логикийн хүндрэл бэрхшээл 2021 оны дэлгүүрийн борлуулалт болон дэлгүүрийн тэлэлтэд сөрөг нөлөө үзүүлсээр байсан ч, 2021 онд өмнөх 2020 онтой харьцуулахад дэлгүүрийн тоо 60 хувиар, борлуулалтын орлого 107 хувиар тус тус өсжээ.

Харьцуулагдахуйц дэлгүүрийн дундаж борлуулалтын өсөлт/бууралт, хувиар

	2021	2020
Өөрийн дэлгүүр	+35%	-27%
Франчайз дэлгүүр	+40%	N/A

2021 онд харьцуулагдахуйц дэлгүүрүүдийн дундаж борлуулалт өөрийн дэлгүүрийн хувьд 35 хувиар, франчайз дэлгүүрийн хувьд 40 хувиар өссөн байна.

Борлуулалтын өртөг, нийт ашиг алдагдал

Оны дунд үед 80 дэлгүүртэй ажилласан 2020 онтой харьцуулахад, оны дунд үед 127 дэлгүүртэй ажилласан 2021 онд нийт алдагдал нь 5.4 тэрбум төгрөгөөс 6.9 тэрбум төгрөгт хүрч 27.7 хувиар өссөн байна. Энэ нь 2020 онтой харьцуулахад 2021 он нь бизнесийн цар хүрээ тэлж, нэгж дэлгүүрийн гүйцэтгэл сайжирсныг харуулж байна. Конвиениес сүлжээ дэлгүүрийн бизнес загварын дагуу, Компани нь олон дэлгүүртэй болж, борлуулалтын дүн өссөнөөр үр ашиг нэмэгдэж ашигт ажиллагаа руу ойртсоор байна. Үүнийг бид нийт ашгийн маржин 2019 онд -15.7 хувь, 2020 онд -11.8 хувь, 2021 онд -7.3 хувь болж тасралтгүй сайжирч байгаагаас харж болно. Цаашлаад, нэгж дэлгүүрийн түвшинд задалж харвал, өмнө жилүүдэд нээгдсэн буюу харьцуулагдахуйц дэлгүүрүүдийн борлуулалт 2020 онтой харьцуулахад 2021 онд сайжирч байна.

Компанийн хурдацтай тэлэлт, борлуулалтын өсөлтөөс үүдэлтэйгээр эдийн засгийн үр ашиг бий болж 1) бараа бүтээгдэхүүний өртөг буурах, 2) тогтмол зардлуудын борлуулалтад эзлэх хувь буурах нөхцөлүүд зэрэг бүрдэж байна. Борлуулалтын өртөгт бараа, бүтээгдэхүүний өртгөөс гадна бусад дэлгүүрийн үйл ажиллагаатай холбогдох зардлууд багтсан бөгөөд, 2021 оны хувьд 6 тэрбум төгрөгийн элэгдэл, хорогдлын зардал багтсан байна.

Ерөнхий, удирдлага, борлуулалтын зардал

2020 онтой харьцуулахад 2021 онд ерөнхий, удирдлага, борлуулалтын зардал 54.4 хувиар өссөн нь борлуулалтын өсөлтийн хувиас даруй 2 дахин бага байна. Компанийн бүтэц зохион байгуулалт өнгөрсөн 3 гаруй жилийн хугацаанд бүрэлдэж, цаашид тогтвортой байх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл, ерөнхий, удирдлага, борлуулалтын зардал дах дэлгүүрийн тэлэлтээс шууд хамааралгүй бүрдэл нь цаашид тогтвортой байх нөхцөл бүрдэж

байна. Уг зардалд багтсан цаашид дахин тохиохгүй зардал нь IPO буюу хувьцаа гарган олон нийтэд санал болгосонтой холбоотой 0.8 тэрбум төгрөгийн зардал юм. Эдгээр нь маркетингийн үйл ажиллагаа, хөндлөнгийн мэргэжлийн байгууллагын холбогдох ажил үйлчилгээтэй холбоотой зардлууд юм. Ерөнхий, удирдлага, борлуулалтын зардлыг нийт сүлжээний борлуулалттай харьцуулахад 2020 онд 10.0 хувь байснаас 2021 онд 7.2 хувь болж буурсан байна. Ерөнхий, удирдлага, борлуулалтын зардал нь бизнесийн нийт цар хүрээг дэмжих зорилгоор гардаг тул нийт сүлжээний борлуулалттай харьцуулж харах нь зохистой юм.

Цэвэр санхүүгийн зардал

Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардал болон санхүүгийн түрээсийн хүүний зардлаас бүрдэж байна. Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түрээсийн зардлыг санхүүгийн түрээсийн хүүний зардал болон ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардлаар салгаж бүртгэдэг. Өөрөөр хэлбэл, өөрийн дэлгүүр нэмэгдсэнээр уг зардал өсдөг буюу 2021 онд шинээр нээгдсэн дэлгүүрүүдийн тоо, мөн нэмэгдсэн франчайз салбарын тооны зөрүүгээр нь уг зардал өссөн гэж хэлж болно. Нийт санхүүгийн зардал доторх зээлийн хүүний зардал буурсан байгаа нь 2021 онд санхүүжилтийн бүтцийн өөрчлөлт хийж, Компанийн урт хугацаат зээлийн дүнг бууруулснаас үүдэлтэй байна.

Мөнгөн гүйлгээний үзүүлэлтүүд, тэрбум төгрөг

	2021	2020
Ажлын капиталын өмнөх үйл ажиллагааны МГ	(1.3)	(5.0)
Ажлын капиталын МГ*	2.7	(3.0)
Санхүү, татварын МГ	(5.2)	(5.1)
Үйл ажиллагааны цэвэр МГ*	(3.8)	(13.2)
Хөрөнгө оруулалтын МГ*	(13.7)	(7.6)
Санхүүжилтийн МГ*	32.1	26.2
Цэвэр МГ	14.7	5.5

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө эхний үлдэгдэл

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө эцсийн үлдэгдэл*	20.8	6.1
---	-------------	------------

*Холбоотой талын өглөгийн гүйлгээ болон богино хугацаат бондын хөрөнгө оруулалтыг тохируулга хийж оруулсан.

Санхүүгийн байдлын тайлан, тэрбум төгрөг

	2021	2020	Ж/ж%
Эргэлтийн бус хөрөнгө	74.7	40.6	+84%
Эргэлтийн хөрөнгө	41.3	16.3	+153%
Нийт хөрөнгө	116.0	56.9	+104%
Урт хугацаат өр төлбөр	41.4	30.1	+38%
Богино хугацаат өр төлбөр	30.5	43.2	-29%
Нийт өр төлбөр	72.0	73.3	-2%
Нийт эздийн өмч	44.0	-16.4	+369%

Мөнгөн гүйлгээ

Конвиениенс сүлжээ дэлгүүрийн бизнес загвар нь олон тооны дэлгүүртэй, томоохон үйл ажиллагаанаас мөнгөн урсгалтай болох зорилготой байдаг ба, цаашид ашигт ажиллагаа сайжирснаар үйл ажиллагааны мөнгөн урсгал ихсэж, бизнес өөрийн шаардлагатай хөрөнгө оруулалтыг түүгээрээ хангах бүрэн боломжтой болдог. Цаашлаад, зээлийн төлөх, ногдол ашиг, хувьцаа халааслах зэргийг үйл ажиллагааны мөнгөн урсгалаараа санхүүжүүлэх боломжтой.

2020, 2021 онуудад цар тахлаас үүдэлтэй хатуу хөл хорио, онцгой байдлын дэглэмийн үед дэлгүүрийн өдрийн дундаж орлого буурснаар бизнесийн орлого, зардлаас үүдэлтэй мөнгөн урсгалд сөрөг нөлөө их байсан ч, цэвэр эргэлтийн хөрөнгө буюу ажлын капиталын өөрчлөлтөөс үүдэлтэй мөнгөн урсгалын нөлөө эерэг байжээ.

2021 онд үйл ажиллагааны цэвэр МГ нь 3.8 тэрбум төгрөгийн гарах урсгалтай байсан нь 2020 оны дүнгээс 9.4 тэрбум төгрөгөөр сайжирсан байна. 2020 оны үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээнээс санхүүжилтийн мөнгөн гүйлгээнд тооцогдож болохуйц 16.4 тэрбум төгрөгийг тохируулга хийн тооцсон. Энэ нь Премиум Групп ХХК буюу өмнөх толгой компанийн хувьцаа руу хөрвүүлэх зорилгоор санхүүжүүлсэн хоорондын тооцооны өглөг бөгөөд, 2021 онд энгийн хувьцаа руу хөрвөсөн.

Хөрөнгө оруулалтад 2021 онд 13.7 тэрбум төгрөг зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 80 орчим хувийн өсөлттэй байна. 2021 оны хөрөнгө оруулалтын мөнгөн урсгалаас 16.7 тэрбум төгрөгийн богино хугацаат санхүүгийн хэрэгслийн хөрөнгө оруулалт болон богино хугацаатай зээлийн мөнгөн урсгалын тохируулга хийж дээрх хүснэгтэд тусгасан. Цар тахлын уршгаар БНХАУ хилээ хаасан

нь дэлгүүрийн тэлэлтэд хүндрэл учруулсан бөгөөд мөнгөн хөрөнгийн удирдлагын хүрээнд, Компани богино хугацаат хөрөнгө оруулалт, зээл олгох замаар хүүний орлогыг нэмэгдүүлсэн.

2021 онд 32.1 тэрбум төгрөгийн цэвэр санхүүжилтийг татан төвлөрүүлсэн бөгөөд үүнд 29.6 тэрбум нь нэмж хувьцаа гаргаснаар, 5.2 тэрбум төгрөг нь нэмж зээл авснаар бий болсон. Зөрүү 2.69 тэрбумын бууралт нь санхүүгийн лизингийн төлөлт, зээлийн төлөлт байна. Компанийн тохируулсан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл 2021 болон 2020 онуудад тус тус 20.8 тэрбум төгрөг болон 6.1 тэрбум төгрөг байв.

Санхүүгийн байдал

Эргэлтийн бус хөрөнгө

Компанийн хөрөнгийн дийлэнх хэсгийг биет хөрөнгө болон ашиглах эрхтэй хөрөнгө эзэлж байна. Бид хоол үйлдвэрлэлийн төв болон хүйтэн хэлхээт түгээлтийн төвийг охин компаниар дамжуулан 100 хувь эзэмшдэг бол дэлгүүрийн байгууламж, хэвийн температурын түгээлтийн төв болон оффисын байрыг түрээсээр ашиглаж байна. 2021 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар манай компани 165 дэлгүүр, 1 хоол үйлдвэрлэлийн төв, 1 хүйтэн хэлхээт түгээлтийн төв, 1 хэвийн температурын түгээлтийн төвтэй үйл ажиллагаа явуулж байна. Бид одоогийн ашиглаж буй байршлуудын үйл ажиллагаа явуулах стандарт, чанарын шаардлагыг сайтар хангасан. Компани нь дэлгүүрүүд дэх түрээсийн сайжруулалт, ширээ, сандал, тавиур, лангуу, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, систем, хөргөгч, хөлдөөгч, хоол үйлчилгээний төхөөрөмж зэрэг бүхий л биет хөрөнгүүдийг эзэмшдэг. 2021 онд эргэлтийн бус хөрөнгийн төлөвлөгөөнд хүрээгүй нь дэлгүүрийн тэлэлтийн удаашралттай холбоотой байна.

Эргэлтийн хөрөнгө

Эргэлтийн хөрөнгийн ихэнх хэсгийг бараа материал, богино хугацаат хөрөнгө оруулалт болон мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө эзэлж байна. Борлуулалтын орлогын өсөлттэй шууд уялдаатайгаар буюу дэлгүүрийн тооны өсөлтөөс хамаарч бараа материалын дүн 110 хувиар нэмэгдэж 14.1 тэрбум төгрөгт хүрсэн. Бараа материалын дүнд худалдан борлуулах зориулалттай бараа бүтээгдэхүүнээс гадна дэлгүүрийн тэлэлттэй холбоотой хангамжийн материал, барилгын материал тоног төхөөрөмж багтсан. Бараа материалын дүн нь Компанийн санхүүгийн төлөвлөгөөнөөс 27 хувиар илүү байгаа бөгөөд үүний үндсэн шалтгаан нь логистикийн хүндрэлээс үүдэлтэй бараа бүтээгдэхүүний тасалдлаас сэргийлж нөөц үүсгэсэнтэй холбоотой.

Түүнчлэн, 2021 оны 4-р улиралд гүнзгийрсэн логистикийн хүндрэлээс үүдэлтэйгээр дэлгүүрийн тэлэлт удааширсан ба тус хугацаанд Компанийн зүгээс бэлэн мөнгөний удирдлагын (treasury management) үйл ажиллагаа хэрэгжүүлэн богино хугацаанд тогтоосон хугацаанд тогтоосон үнээр буцаан худалдах (репо) хэлцэлтэйгээр бондуудад хөрөнгө оруулсан. Үүний үр дүнд эргэлтийн хөрөнгөнд 14.9 тэрбум төгрөгийн өрийн үнэт цаас, 2 тэрбум төгрөгийн богино хугацаат өрийн бичгийн хөрөнгө оруулалтууд бүртгэгдсэн.

Өглөг

Урт хугацаат өр төлбөрт урт хугацаат зээл болон урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг багтдаг. 2021 оны дэлгүүр тэлэлтийн төлөвлөгөө хангагдаагүйгээс шалтгаалан урт хугацаат санхүүгийн түрээсийн өглөг төлөвлөснөөс бага байсан. Богино хугацаат өглөгийн хувьд дийлэнх хэсгийг дансны өглөг болон богино хугацаат санхүүгийн түрээсийн өглөг эзэлж байна. Дансны өглөгийн хэмжээ төлөвлөгөөнөөс давсан нь логистикийн эрсдэлийг бууруулах зорилгоор бэлтгэн нийлүүлэгчдээс бараа материалын нөөц татсантай холбоотой.

Эздийн өмч

2021 онд хувьцаат капиталын нэмэгдүүлэлт хийгдсэнтэй холбоотойгоор эздийн өмчийн хэмжээ нь 2020 оноос 60 тэрбум төгрөгөөр нэмэгджээ. 2021 оны санхүүгийн төлөвлөлтөөс сайн үр дүнтэй гарсан шалтгаан нь а) Компани

төлөвлөснөөс бага алдагдалтай ажилласан, б) төлөвлөснөөс өндөр дүнгээр хувьцаат капиталын нэмэгдүүлэлт хийгдсэн байна.

Харьцаа үзүүлэлтийн шинжилгээ

Хөрвөх чадвар

Компанийн эргэлтийн хөрөнгө нь эргэлтийн өр төлбөрөөс өндөр байгаа нь эргэлтийн хөрөнгөөс бараа материалыг хасагдуулж тооцоход ч эргэлтийн өр төлбөрийн 90 хувийг төлж чадахаар байгаа нь хөрвөх чадварын харьцаа өндөр байгааг харуулж байна. Тус харьцааг төлбөр түргэн гүйцэтгэх чадварын (ТТГЧ) харьцаа гэх бөгөөд энэ нь 0.9 буюу 1-ээс бага байгаа нь бараа материалын нөөцийг нэмэгдүүлсэнтэй холбоотой. 2020 онд ТТГЧ харьцаа нь 0.2 байсан нь өмнөх толгой компани буюу Премиум Групп ХХК-ийн энгийн хувьцаа руу хөрвүүлэхээр хөрөнгө оруулсан дүнг Хоорондын тооцооны өглөг гэж бүртгэсэнтэй холбоотой.

Төлбөрийн чадвар

Өрийн харьцаа 2020 онд 1.3 байсан бол 2021 онд 0.6 болсон нь Компанийн санхүүжилтийн бүтэц дэх өөрийн хөрөнгийн хэмжээ нэмэгдэж, зээлийн санхүүжилтийн дүн буурсантай холбоотой.

2021 онд Компани 19.8 тэрбум төгрөгийн богино хугацаат өглөг (өмнөх толгой компанийн хоорондын тооцоо), 16.2 тэрбум төгрөг бүхий урт хугацаат зээл (Голомт банкны зээл) нийт 36.2 тэрбум төгрөгийн өр төлбөрийг эздийн өмч рүү шилжүүлсэн. Мөн Компанийн хувьцаа нэмж гарган олон нийтэд санал болгосноор эздийн өмч 27.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээр Компанийн санхүүжилтийн бүтэц дэх зээлийн дүн буурч, төлбөрийн чадварын харьцаа сайжирсан.

Үйл ажиллагааны харьцаа


Бэлэн мөнгөний цикл 2020 онд -29 хоног байснаас -39 хоног болж 10 хоногоор сайжирсан үзүүлэлттэй байна. Энэ нь төлбөр гүйцэтгэх дундаж хугацаа нэмэгдсэнтэй холбоотой ба 4-р улиралд бараа материал нэмж нөөцөлсөнтэй холбоотой байна.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл

2021 онд Компани нь Премиум Групп ХХК-ийн 100 хувийн эзэмшилд байсан Премиум Дистрибьюшн ХХК-ийг 7.7 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий хувьцаа гарган худалдаж авсан. Уг шийдвэр Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 100 хувийн саналаар дэмжигдсэн. Бусад зөрчилтэй хэлцлийн дүнг доорх хүснэгтэд тусгав.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн дүн, тэрбум төгрөг

	Хувьцаа эзэмшигчид	Хувьцаа эзэмшдэг компани	Бусад хамааралтай тал
Бараа материал худалдан авалт	2.8	-	1.5
Үндсэн хөрөнгө борлуулалт	-	2.0	-
Хүүгийн зардал	1.2	-	-
Бэлэн бүтээгдэхүүний борлуулалт	-	0.06	-
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	-	1.0	0.7
Хүүгийн орлого	-	0.02	-



2.2. Стратегийн чиглэл болон гүйцэтгэл

Бид хэрэглэгчийн хувьсан өөрчлөгдөж буй амьдралын хэв маягт тохирсон хоол, хүнс болон бусад өдөр тутмын үйлчилгээг нэг дороос, хамгийн ойроос, ая тухтай орчинд түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэхийн төлөө ажилладаг.

Цаашид бид хэрэглэгчдэдээ илүү ойр байршиж, илүү оновчтой бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх зорилтдоо хүрэхийн тулд дараах 5 стратегийг дунд хугацаанд хэрэгжүүлэхээр төвлөвөөд байна.

Зах зээлд давамгайлах стратеги

Бид хэрэглэгчдийнхээ дийлэнх цагаа өнгөрүүлдэг цэгүүдэд CU дэлгүүрүүдээ нээн хэрэглэгчдэдээ илүү ойртож, тэдний цаг, мөнгө, эрч хүчийг хэмнэх боломж бүрдэх ба хэрэглэгчид маань илүү үнэ цэнтэй зүйлд бүтээхэд өөрсдийн цаг хугацаа, нөөцийг зарцуулж улсынхаа хөгжилд хувь нэмэр ээ оруулах боломжтой болох юм.

Иймд бид салбар дэлгүүрийнхээ тоог илүү хурдтай нэмэгдүүлж, зах зээл дээр давамгайлах стратегийг баримтлан ажиллаж байна. CU дэлгүүрийн хувьд үр ашигтай түгээлтийн системийг бий болгох, CU брэндийг олон нийтэд таниулах, жижиглэнгийн худалдааны зах зээл дээр өөрийн салбарын тоо болон борлуулалтын орлогоор тэргүүлэх, олон салбарыг даган өргөжилтийн эдийн засаг (economies of scale) сайжирч ашгаа өсгөх зэрэг давуу талуудыг бий болгоно.

Бид иргэдэд хэрэгтэй үйлчилгээг ойртуулах, бизнесийн өсөлтийг тогтвортой хадгалах зорилгынхоо хүрээнд 2021 онд CU дэлгүүрийн тоогоо 165-д хүргэсэн бөгөөд 2022 оны 1-р улиралд нэмж 32 салбар дэлгүүрийг хотын төвийн, хүн амын төвлөрөл ихтэй бүсүүд болон хотын захын чухал хэсгүүдэд нээсэн. Ингэснээр манай нийт дэлгүүрийн тоо 197-д хүрсэн.

Бид сүүлийн 4 гаруй жилийн хугацаанд хүн амын төвлөрөл өндөртэй бүсүүд болон зорчигч тээврийн зангилаа цэгүүдийг судалж, конвiniенс дэлгүүрийн хэрэгцээ хамгийн өндөр байх магадлалтай байршлуудыг тогтоогоод байгаа бөгөөд 2023 оны эцэст нийт 360 байршилд CU дэлгүүрийг нээхээр зорин ажиллаж байна.

Босоо интеграцийн стратеги

CU конвiniенс сүлжээ дэлгүүр нь хэрэглэгчдэд хамгийн ойр хүрч чадах нэгдсэн стандарт бүхий олон тооны салбараас бүрддэг. Олон дэлгүүрийг нэгтгэснээр худалдан авалтын хүч, бизнес хөгжүүлэлтийн боломжууд бүрдэх ба тэдгээр дэлгүүрийг өдөр бүр ижил стандарт, нэгдсэн стандартаар хангаж ажиллах сорилт үүсдэг. Тиймээс, олон дэлгүүрийг хангаж ажиллаж чадах дэд бүтэц нь уг бизнесийн хөдөлгөгч хүч болдог.

200, 300, 400 дэлгүүрийг ханган ажиллаж чадах а) “Хоол хөгжүүлэлт, үйлдвэрлэлийн төв”, б) “Агуулах, түгээлт, логистикийн нэгдсэн төв”, в) цахим холбоо, мэдээллийн урсгалын нэгтгэсэн IT тогтолцоог бий болгох нь Сентрал Экспресс Си Ви Эс ХК-ийн урт хугацааны тогтвортой байдлын үндэс суурь болно.

Түгээлтийн дэд бүтэц. Бид үйлчлүүлэгчдийн өдөр тутмын хэрэгцээт бараа, ялангуяа хоол, хүнсний барааг дэлгүүрүүддээ тасралтгүй бэлэн байлгахын зорин ажилладаг ба эдгээр бүтээгдэхүүнүүдэд хэвийн ба хөргүүртэй горим бүхий агуулах, түгээлтийн тогтолцоо шаардлагатай болдог. Уламжлалт хүнсний дэлгүүртэй харьцуулахад олон тооны дэлгүүр нэгдсэн удирдлагаар бараа бүтээгдэхүүнээ нийлүүлдэг учраас шөнийн цагийн хүргэлт зохион байгуулах, өдөр тутам хэрэгцээт хэмжээгээр түгээх зэрэг олон давуу талууд бий болдог. Дэлгүүрийн тоо өсөхийн хэрээр уг төрлийн дэд бүтэц шаардлагатай болох, нөгөө талаас дэд бүтцэд хийсэн хөрөнгө оруулалтын өгөөж нэмэгдэх юм. Тиймээс бид IPO-ын татан төвлөрүүлсэн санхүүжилтээр түгээлт, логистикийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж хүчин чадлыг өргөтгөсөөр байна. Ингэснээр 2 ээлжээр тасралтгүй ажиллаж, 400 хүртэлх дэлгүүрийн бараа бүтээгдэхүүнийг өдөр бүр ханган нийлүүлэх боломжтой түгээлтийн тогтолцоотой болж байна.

Тус санхүүжилтээр 2021 оны сүүл үеэс агуулахын үйл ажиллагааны удирдлагын системийг шинэчлэх, захиалга бэлтгэх хагас автомат системийг суурилуулах, хүйтэн хэлхээний түгээлтийн төвийг өргөтгөх төслүүдийг амжилттай эхлүүлээд байгаа ба эдгээр системүүдийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр агуулахын захиалга бэлтгэх хурдыг 2 дахин нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

Хоол үйлдвэрлэлийн төв. Компани нь чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлын өндөр шаардлагыг хангасан 4,000 м² талбай бүхий хоол үйлдвэрлэлийн төвийг 2020 онд ашиглалтад оруулсан бөгөөд 2021 онд уг үйлдвэрийн өдрийн дундаж бүтээгдэхүүний гарцыг 3 дахин нэмэгдүүлжээ. 2022 онд CU дэлгүүрийн тооны өсөлттэй уялдан хоол үйлдвэрлэлийн гарцыг нэмэгдүүлэх ба цаашид 400 хүртэлх CU дэлгүүрүүдийн эрэлт хэрэгцээг тасалдалгүй хангаж ажиллах хүчин чадалтай юм.

Цогц мэдээллийн систем. Компани конвiniенс сүлжээ дэлгүүрийн бизнесийн үйл ажиллагаа буюу өдөр тутмын худалдан авалт, түгээлт, маркетинг, борлуулалтын үйл ажиллагааг улам сайжруулах зорилгоор олон улсын конвiniенс бизнесийн нөү хау шингэсэн жижиглэн худалдааны цоо шинэ мэдээллийн системийг одоогийн системдээ нэгтгэн сайжруулах ажлыг эхлүүлсэн бөгөөд энэ 2022 онд бүрэн гүйцэт ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Бүтээгдэхүүнээр ялгарах стратеги

Конвiniенс дэлгүүр нь зах зээлд шинэлэг бүтээгдэхүүн, хэрэглэгчид өдөр тутамд шаардлагатай, илүү үнэ цэн өгсөн үйлчилгээг тасралтгүй нэвтрүүлж ойр орчмынхоо нийтийн үйлчилгээний төв болох замаар өрсөлдөөнд ялгардаг. CU конвiniенс дэлгүүр нь бүтээгдэхүүний ялгарал, шинэлэг, тренд байдлыг бий болгох стратегийн хүрээнд бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг тогтмол шинэчилж байна.

Нэрийн бүтээгдэхүүн. GET, CU Eats, HEYROO, Гоёдоог зэрэг брэнд нь зөвхөн CU конвiniенс дэлгүүрүүдээр борлуулагддаг манай нэрийн бүтээгдэхүүн бөгөөд эдгээр бүтээгдэхүүнүүд нь байнгын үнэнч хэрэглэгчийг бий болгох чухал үүрэгтэй юм. Бид 2021 онд нэрийн бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг 45 хувиар нэмэгдүүлж борлуулалтыг 114 хувиар өсгөсөн үр дүнтэй ажилласан.



Онцгой эрхтэйгээр борлуулдаг бүтээгдэхүүн. Бид CU-тэй зайрмаг, iBerry жимсний шүүс, Фрэшбокс сэндвич зэрэг тодорхой нийлүүлэгч, үйлдвэрлэгчидтэй хамтран зарим нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн онцгой эрхтэйгээр борлуулдаг билээ. Ингэснээр бид дотоодын үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг олон нийтэд таниулж байгаагийн зэрэгцээ хэрэглэгчдэдээ CU брэндийн онцлог, давуу талыг шингээсэн цоо шинэ мэдрэмж, үнэ цэнийг хүргэж байна. Бид 2021 онд

онцгой эрхтэйгээр борлуулдаг бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг 38 хувиар нэмэгдүүлж CU дэлгүүрийн борлуулалтыг 108 хувиар өсгөөд байна.



Импортын бүтээгдэхүүн. Бид дэлхийн олон орны конвинеенс дэлгүүрүүдэд тренд болж байгаа хэдий ч Монголын зах зээлд нэвтрээгүй бүтээгдэхүүнийг импортлон CU конвинеенс сүлжээ дэлгүүрүүдээрээ борлуулдаг бөгөөд бид 2021 онд импортын бүтээгдэхүүний нэр төрлийг өмнөх оноос 102 хувиар нэмэгдүүлж Ази, Европ, Америк тивийн 6 орноос 500 нэр төрлийн бүтээгдэхүүнийг импортлон бөгөөд энэ нь Компанийн импортын бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг 117 хувиар нэмэгдүүлэхэд нөлөөлсөн. Цаашид бид импортын бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг нэмэгдүүлж, бүтээгдэхүүний шинэлэг байдлыг ханган ажиллахаар төлөвлөөд байна.



Тренд бүтээгдэхүүн. Зах зээлд шинээр нэвтрүүлэх боломжтой бүтээгдэхүүнийг илрүүлэх, улмаар зах зээлд түрүүлж нэвтрүүлэх нь бидний хувьд ихээхэн чухал. Өнгөрсөн жилүүдэд нийт 14 мянга гаруй, 2021 онд нийт 3,633 нэр төрлийн шинэ бүтээгдэхүүнийг CU конвинеенс дэлгүүрийн хэмжээнд нэвтрүүлээд байна. Цаашид бид долоо хоног тутамд шинэлэг тренд бүтээгдэхүүнийг сүлжээндээ нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Үйлчилгээний нэгдсэн төв. Конвинеенс дэлгүүрүүд цар хүрээгээ тэлж, хэрэглэгчдэд улам ойртохын хэрээр конвинеенс дэлгүүрийн үйл ажиллагаа хувьсан өөрчлөгдөж байна. Ая тухтай дэлгүүр нь хүний бараа бүтээгдэхүүн худалдан авах хэрэгцээг хангаад зогсохгүй сим карт авах, гар утасны нэгж цэнэглэх, төлбөр төлөх, баримт бичиг хэвлэх, олшруулах, шуудан илгээмж илгээх, хүлээн авах, төрийн болон банкны зарим үйлчилгээг авах, жуулчдад мэдээлэл өгөх зэрэг төрөл бүрийн үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлдэг болоод байна. CU конвинеенс сүлжээний хувьд ч мөн адил эдгээр үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлж, хэрэглэгчдэдээ улам илүү үнэ цэнийг бий болгохыг зорин ажиллаж байгаа бөгөөд 2021 онд CU дэлгүүрт сим карт авах болон онлайн худалдааны Stora box үйлчилгээнүүдийг шинээр нэвтрүүлж, дэлгүүртээ байрших АТМ-ийн тоог 44 хувиар нэмэгдүүлснээс гадна нийт 165 салбар дэлгүүртэй болсноор Улаанбаатар хотын нийтэд нээлттэй ариун цэврийн өрөөний тоог нэмэгдүүлээд байна.


Үнэнч хэрэглэгчийг нэмэгдүүлэх стратеги

CU конвинеенс дэлгүүрийг өдөр тутам сонгон үйлчлүүлдэг үнэнч хэрэглэгчид маань бидний хувьд хамгийн чухал. Бид үнэнч хэрэглэгчдэдээ давуу үнэ цэнийг санал болгохыг эрмэлзэн ажилладаг. Бид 2021 онд олон шатлал бүхий урамшуулалт онооны систем, төрөл бүрийн даалгавар биелүүлэх боломжтой купон, зөвхөн гишүүдэд зориулсан хямдрал урамшуулал, давтан худалдан авалтыг дэмжих хөтөлбөр зэрэг олон хувилбарт модулийг хөгжүүлэн нэвтрүүлэлтийн шатанд хүргээд байна.



Найрсаг, дотно үйлчилгээг хүргэх. CU конвинеенс дэлгүүрийн “Сайн байна уу? CU-д тавтай морил” хэмээн мэндчилэх зэрэг бидний үйлчилгээний


соёл нь хэрэглэгчдэд хэдийн танигдсан бөгөөд Улаанбаатар хотын үйлчилгээний стандартыг 1 шат ахиулж урт хугацааны үнэ цэнийг бүтээсэн. Бид чанар, үйлчилгээ, ариун цэврийн стандартыг үйл ажиллагаандаа өдөр бүр мөрдлөг болгон ажилладаг. CU дэлгүүрийн ажилтнууд нь чадвартай, идэвх санаачилгатай, хэрэглэгч төвтэй, зөв хандлагатай байх нь чанар, үйлчилгээний стандартыг хэвшүүлэх, брэндийн үнэ цэнийг хадгалахад гол нөлөө үзүүлдэг. Бид дэлгүүрийн ажилтнуудыг тогтмол сургаж хөгжүүлэх, урамшуулах, карьер өсөлтийг нь дэмжих замаар стандартыг тогтвортой хадгалж, Монголын хамгийн сэтгэлд ойр үйлчилгээтэй дэлгүүр байхыг зорин ажилласаар байна. Бид стандартыг бүх салбар дэлгүүрүүддээ жигд хэрэгжүүлэх бодлогын хүрээнд 2021 онд сонгон шалгаруулалтыг чанаржуулж, салбар дэлгүүрийн гүйцэтгэлээс хамаарсан таазгүй цалингийн системийг нэвтрүүлэн ажилласнаар хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнийг өмнөх оноос 21.8 хувиар бууруулж ажилтны сэтгэл ханамж, оролцооны түвшнийг өсгөж чадсан бөгөөд 2021 онд давтагдсан тоогоор нийт 3,209 ажилтанд найрсаг дотно үйлчилгээ, стандартын мэдлэг, харилцааны ур чадвар олгох, удирдах ур чадварын сургалт зохион байгуулж, дотоод сургалтын системийг нэвтрүүлж цахим сургалтын 40 контент шинээр бий болгоод байна.



Үнэнч хэрэглэгчийг урамшуулах. 2021 онд CU брэндийн үнэнч хэрэглэгчдийн нийт худалдан авалтын борлуулалтад эзлэх хувийг өмнөх онтой харьцуулахад 32 хувиар, худалдан авсан барааны тоо ширхэг 31 хувиар өссөн нь тус хөтөлбөрийг үргэлжлүүлэн хөгжүүлэх улам их итгэл найдвар, урам зоригийг бидэнд өгсөн бөгөөд бид цаашид CU аппликейшн хэрэглэгчдийн худалдан авалтын өгөгдлийн судалгааг боловсронгуй болгох замаар хэрэглэгчийн хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгохоор зорьж байна.

Технологийн дэвшилд тулгуурлан борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх

Сувгийн төрөлжилт (Omnichannel). Бид CU сүлжээ дэлгүүрүүдээрээ хэрэгцээт үйлчилгээг хүргэхээс гадна хэрэглэгчдэдээ улам ойртож сэтгэлд хүрсэн үйлчилгээг үзүүлэх зорилгоор онлайн захиалга, хүргэлтийн үйлчилгээний сувгийг нэвтрүүлсэн нь маш шинэлэг, өндөр эрэлттэй үйлчилгээ болсон. Түүнчлэн бид хэрэглэгчдэдээ хэрэгцээт барааг ердөө 30 минутын дотор хүргэдэг болсон бөгөөд 2021 онд хүргэлтээр үйлчлүүлэгчийн тоо 7.9 дахин нэмэгдсэн.



Финтек (Fintech). Бид хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцэж ажиллах зорилгынхоо хүрээнд CU дэлгүүртээ бүх төрлийн төлбөрийн шийдлүүдийг нэвтрүүлж иргэдийн идэвхтэй ашигладаг SocialPay, QPay, Monpay, MongolChat, HiPay, Toki зэрэг дижитал хэтэвчний үйлчилгээг холбосноор төлбөр тооцоог хялбар гүйцэтгэх боломжийг бүрдүүлээд байна. 2021 онд CU дэлгүүрүүдэд нийт 339 мянган гүйлгээг дижитал хэтэвчээр дамжуулан хийсэн байна.

Бид цаашид үйлчилгээний хурдыг нэмэгдүүлэх, төлбөр тооцооны аюулгүй байдлыг хангах, бэлэн мөнгөтэй холбогдон гардаг зардлыг бууруулах, CU аппликейшнийг цахим хэтэвч хэлбэрээр хөгжүүлж төлбөр тооцоо, мөнгөн шилжүүлэг, зээл болон бусад төрлийн санхүүгийн бүтээгдэхүүнийг ашиглах боломжийг бүрдүүлэх зорилго тавин ажиллаж байна.

Технологийн шийдлүүд (In-store tech). CU конвинеенс дэлгүүрийн бүх салбарууд нь видео хяналтын нэгдсэн систем, клауд дээр суурилсан дуу хөгжим тоглуулах болон зарлан мэдээлэх систем, клауд менежмент бүхий дижитал дэлгэцүүдийг бүх салбар дэлгүүрүүддээ байршуулаад байна. Ингэснээр бид CU дэлгүүрээр үйлчлүүлж буй хэрэглэгчдэд шинэ бүтээгдэхүүн, хямдрал урамшуулал, бусад онцлох мэдээ мэдээллийг нэгдсэн байдлаар түргэн шуурхай хүргэх боломжтой болж байгаа юм.

2.3. Өрсөлдөөний орчин


Монгол Улсын худалдааны салбар

Худалдааны салбар нь хүн амын өсөлт, өрхийн худалдан авах чадвараас шууд хамааралтай салбар бөгөөд 2016-2021 онд жилд дунджаар 16.0 хувийн хурдтай өсөлтийг үзүүлжээ. Жижиглэнгийн худалдааны салбарын хувьд 2020 онд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр борлуулалтын хэмжээ 2.1 хувийн өсөлттэй байсан бол 2021 онд цар тахлын нөлөө буурснаар 24.2 хувийн өсөлтөд хүржээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамаас мэдээлснээр 2020 оны 6 сарын байдлаар Монгол Улсад нийт 15,763 жижиглэн худалдаа эрхлэгчид үйл ажиллагаа явуулж байгаагаас 44 хувь нь Улаанбаатар хотод, 56.2 хувь нь хөдөө орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байна. Жижиглэн худалдааны салбарын 63 хувийг хүнсний дэлгүүр, 14 хувийг мухлаг, 10 хувийг төрөлжсөн барааны дэлгүүр, 1 хувийг конвiniенс дэлгүүр бүрдүүлж байна.

Жижиглэн худалдааны салбарын том ангилалд 2,000 м2-аас дээш талбайтай E-mart, Номин, Миний дэлгүүр зэрэг 33 хайпермаркет, дунд ангилалд 501-2,000 м2 хүртэлх талбайтай Номин, Сансар, Оргил зэрэг 142 супермаркет Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. Харин 500-аас доош м2 талбайтай 6,611 худалдааны суваг Улаанбаатар хотод байгаагаас 8 нэрийн хүнсний дэлгүүр 3,638 ширхэг, мухлаг 1,669 ширхэг тус тус байна.

Жижиглэн худалдааны салбарын бүтэц



Эх сурвалж: www.ub-speeda.com

Жижиглэн худалдааны зах зээлд оролцогчдыг уламжлалт, орчин үеийн, онлайн хэмээн 3 ангилдаг.

Уламжлалт зах зээл

Уламжлалт зах зээлд худалдагч дэлгүүрийн лангуунаас хэрэглэгчтэй шууд харилцах замаар худалдаа, төлбөр тооцоог хийж гүйцэтгэдэг. Монгол Улсын уламжлалт худалдааны зах зээлд задгай зах, 8 нэрийн хүнсний дэлгүүр, мухлаг, ТҮЦ зэрэг дэлгүүр багтдаг.


Орчин үеийн зах зээл

Орчин үеийн зах зээлд хэрэглэгч өөртөө үйлчлэн, бараа бүтээгдэхүүнээ сонгож, тэрэг болон сагсанд хийн кассад очин төлбөр тооцоогоо хийж гүйцэтгэдэг. Монгол Улсын орчин үеийн зах зээлд хайпермаркет, супермаркет, минимаркет, конвiniенс дэлгүүр болон төрөлжсөн дэлгүүр багтаж байна.

Онлайн зах зээл

Онлайн зах зээлд хэрэглэгч онлайн платформ ашиглан төлбөр тооцоо хийх, хүргэлтийн үйлчилгээ авах боломжтой. Монгол Улсад вэбсайт, аппликэйшн, сошиал групп, хуудас зэрэг платформуудаар дамжин онлайн зах зээл хөгжиж байна.

Конвiniенс дэлгүүрийн зах зээлд оролцогчид



Эх сурвалж: Компанийн судалгаа

Монгол Улсын конвiniенс дэлгүүрийн зах зээл

Компани нь Монгол Улсын анхны конвiniенс дэлгүүрийг 2017 онд байгуулсан. Өдгөө жижиглэн худалдааны салбарт конвiniенс дэлгүүрийн зах зээл нь хамгийн хурдтай өсөж байна.

Конвiniенс дэлгүүрийн үүсэл хөгжлөөс харвал Япон, БНСУ-ын зах зээлд богино хугацаанд олон шинэ конвiniенс дэлгүүрийн брэндүүд нэвтэрч, зах зээлд байр сууриа олохын төлөөх ширүүн өрсөлдөөн өрнөсөн түүхтэй. Монгол Улсын конвiniенс дэлгүүрийн зах зээлд ч мөн адил энэ түүх давтагдахаар харагдаж байна.

2021 оны эцсийн байдлаар Улаанбаатар хотод нийт 4 брэндийн 232 конвiniенс дэлгүүр үйл ажиллагаа явуулж байсны 165 нь CU сүлжээ дэлгүүр, 34 нь GS25 брэнд, 21 нь Circle K брэнд, 12 нь Ecoexpress-ийн салбар дэлгүүр байсан байна.

Монгол Улсын нийтийн хоолны үйлчилгээний салбар

Компанийн охин компани болох Премиум Дистрибьюшн ХХК нь хоол үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж борлуулалтаараа Компанийн орлогын томоохон хэсгийг бүрдүүлдэг.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яамнаас мэдээлснээр 2020 оны байдлаар Монгол Улсын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт нийт 8,500 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдагас 47 хувь нь орон нутагт, 53 хувь нь Улаанбаатар хотод байршиж байна.

Үүнд 2,369 цайны газар, 1,570 ресторан, 1,331 бар, 400 кафе, 85 түргэн хоолны газар, эмнэлэг сувиллын 544, сургуулийн 1,600, дотуур байрны 283 зэрэг нийт 8,467 хоолны газар тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

Улсын хэмжээнд нийтийн хоолны үйлчилгээний салбарын орлого 2016-2021 онд жилд дунджаар 21.6 хувиар өсжээ. 2020 онд нийтийн хоолны үйлчилгээний салбарын орлого 7 хувиар буурсан бол 2021 онд 46.7 хувиар өссөн байна.

Улаанбаатар хотын хувьд нийтийн хоолны салбарын орлого 2016-2021 оны хооронд жилд дунджаар 20.6 хувиар өссөн байна.

Улаанбаатар хотын хэмжээнд 1,021 ресторан, 945 бар, 1,297 цайны газар, 225 кафе болон кофе шоп, 2,100 архи согтууруулах төрлийн ундааны тусгай зөвшөөрөлтэй хоолны газар, 950 гаруй гал тогоо бүхий сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний нэгж ажиллаж байна.

2.4. Эрсдэлийн хүчин зүйлс ба удирдлага

Сентрал Экспресс Си Ви Эс ХК нь Улаанбаатар хотод 2021 оны төгсгөлд 165, 2022 оны 3-р сарын 31-ний өдрийн байдлаар 197 салбар конвинеенс дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Сүлжээ дэлгүүрээр өдөр бүр 60,000 түүнээс дээш үйлчлүүлэгч 350-400 бэлтгэн нийлүүлэгчдийн 4,500 орчим нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр үйлчлүүлж байна.

2021 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаарх санхүүгийн мэдээлэлд тулгуурлан боловсруулагдсан Үнэт цаасны танилцуулгад Компанийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнд нөлөөтэй гол эрсдэлүүдийг тодорхойлж тэдгээрийг бууруулахаар компаниас хийгдэж буй ажил, төлөвлөгөөг танилцуулсан билээ. Тус үед Ковид-19-өөс үүдэлтэй хатуу хөл хорио дахин давтагдах, онцгой байдлын дэглэм буурахгүй байх зэрэг нь бизнес, санхүүгийн үр дүнд өндөр нөлөөтэй, мөн үүсэх магадлал ихтэй эрсдэл байсан юм.

2021 оны 2-р хагас жилд Ковид-19 онцгой байдлын дэглэм, олон нийтийн болгоомжлол шат шаттайгаар буурснаар Улаанбаатар хотын хөл хөдөлгөөн сэргэж, Конвинеенс сүлжээ дэлгүүрийн бизнест маш эергээр нөлөөлсөн. Гэсэн хэдий ч, дэлхий, бүс нутгийн, эдийн засаг, бизнесийн орчинд Ковид-19 дараах үр дагаврууд, геополитикийн хурцадмал асуудлууд нь шинэ эрсдэл, сорилтуудыг бий болгож байна. Эдгээрийг товч дурдвал дэлхий даяарх нийлүүлэлтийн хэлхээний доголдол, түүнээс үүдэлтэй үнийн өсөлт, логистикийн бэрхшээлүүд юм. Энэ нь манай улсын эдийн засагт ч маш хүчтэй нөлөөтэй байгааг өндөр инфляцын хувь, гол түүхий эдийн экспортын бууралт, тээврийн үнэ өртгөөс хялбар харж болно.

Бид Үнэт цаасны танилцуулгад дурдсан бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнд хүрэхийг зорин ажиллаж байгаа бөгөөд тус танилцуулгад дурдсан эрсдэлүүдийг нэгтгэн дүгнэхэд дараах 5 эрсдэлийг нь 2022 оны эхний хагас жилд хамгийн нөлөө бүхий, үүсэх магадлал өндөртэй гэж үзэж байна.

Бараа бүтээгдэхүүний тасалдлын эрсдэл.

CU сүлжээ дэлгүүрээр худалдан борлуулагддаг 4500 орчим бараа бүтээгдэхүүний зарим нэр төрөл нь түүхий эд материал, тээвэр логистикийн бэрхшээлээс үүдэлтэй тасрах, захиалгын дагуу ирэхгүй байх зэрэг нөхцөлүүд үргэлж үүсэж байна. Үүнийг даван туулахаар бэлтгэн нийлүүлэгчид шинэ соурсинг хайх, шинэ бүтээгдэхүүнээр орлуулах арга замуудыг тасралтгүй авч хэрэгжүүлж байна. Жишээлбэл, БНХАУ-аас авч байсан бүтээгдэхүүнийг Турк улсаас авдаг болсон зэрэг бусад боломжуудыг эрэлхийлж байна. Бид орлуулах боломжтой шинэ бүтээгдэхүүнийг тодорхойлох, түүнийг хэрэглэгчдэд таниулах ажлуудыг бэлтгэн нийлүүлэгчидтэй хамтарч гүйцэтгэх шаардлага улам ихэссээр байна.

Логистикоос үүдэлтэйгээр тэлэлт удааших эрсдэл.

Дэлгүүр бүтээн байгуулалтад шаардлагатай тоног төхөөрөмж, барилгын материалууд тасалдах нь дэлгүүрийн хөрөнгө оруулалтыг удаашруулах гол эрсдэлүүдийн нэг нь болдог. Бид үүнээс сэргийлэхийн тулд төлөвлөгдсөн хөрөнгө оруулалтын зарцуулалтыг урьдчилан гаргах замаар нөөц үүсгэх арга хэмжээг авсаар байна. Ингэснээр гадаад нийлүүлэгчийн үнийн өсөлт, тасалдал, валютын ханшийн өсөлтөөс үүдэлтэй эрсдэлүүдийг ч даван туулах боломжтой гэж үзэж байна.

Гадаад валютын ханшийн чангаралт, инфляцын эрсдэл.

Валютын ханшийн чангаралт, барааны өртгийн өсөлтөөс үүдэлтэйгээр худалдан борлуулах бараа бүтээгдэхүүний үнэ нэмэгдсээр байна. Компани нь бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэгч биш учраас үнийг тогтвортой барих боломж хязгаарлагдмал.


Үнийн өсөлтөөс шалтгаалан хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн бодит орлого буурч байгаа учраас худалдан авалтын сонголтод өөрчлөлт орсоор байна. Гэсэн хэдий ч, компанийн хувьд өдөр тутмын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулдаг учраас уг эрсдэл нь бусад үнээс хамаарсан эрэлтийн мэдрэмж өндөртэй бүтээгдэхүүнүүдтэй харьцуулахад харьцангуй бага гэж үзэж байна. Компани бэлтгэн нийлүүлэгчидтэйгээ хамтран бусад өртөг хямд сонголтуудыг судлах ажлуудыг тасралтгүй хийх шаардлагатай.

Гадаад валютын ханшийн өсөлт нь дэлгүүрийн бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн төгрөг өртгийг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Тиймээс бид тоног төхөөрөмжийн нөөцийг урьдчилан татах, төлбөрт шаардлагатай валютын нөөц үүсгэх ханшийг урьдчилан тодорхойлох ажлуудыг гүйцэтгэх шаардлагатай болж байна.

Валютаарх төлбөр тооцоо удааших эрсдэл.

2021 оны сүүл үеэс эхлэн Монгол Улсын экспортын гарц буурснаар ам.долларын нөөц багасах хүлээлт үүссэн. Үүнтэй зэрэгцэн дотоодын зах зээл дээрх ам.долларын эрэлт ихэссэнээр долларын нөөц хурдтай буурч, долларын олдоц багассан. Энэ нь импортын бараа бүтээгдэхүүнээс өндөр хамааралтай манай улсын хувьд бүтээгдэхүүн худалдан авах төлбөрөө цаг хугацаанд нь төлж чадахгүй болох, мөн гадаад валютаарх зээлийн төлөлтийг хоцроох зэрэг эрсдэлүүдийг үүсгэж байна. Компани нь валютын эрэлт хэрэгцээгээ нарийн тодорхойлж шаардлагатай нөөцийг тасалдуулахгүй байх тал дээр гадаад, дотоодын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтарч ажиллах шаардлага нэмэгдсээр байна.

Эрсдэлийн матриц



3. Тогтвортой хөгжлийн тайлан

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь бизнесийн тогтвортой хөгжлийг эрхэмлэн салбартаа анх удаа сүлжээ дэлгүүрүүд, нэгдсэн түгээлтийн төв, хоол үйлдвэрлэлийн төв гэсэн үйл ажиллагааны бүх шатанд байгаль орчин, нийгэм, засаглал (“БОНЗ”) -ын суурь үнэлгээг хийлгэсэн.

Олон Улсын Санхүүгийн Корпорацын Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандарт, конвенц, тунхаглал болон Монгол Улсын холбогдох хууль, стандарт, журамд заасан 182 шалгуур үзүүлэлтийг суурь үнэлгээ болгон авч үзсэн бөгөөд үүнээс Компани нь нийт 174 шалгуурыг бүрэн хангаж 95.6 хувийн биелэлттэй гарсан.

Компани нь Нийслэлийн Цагдаагийн Ерөнхий Газрын Гэр Бүлийн Хүчирхийлэл, Хүүхдийн Эсрэг Гэмт Хэрэгтэй Тэмцэх Газартай хамтран хүүхэд хамгааллын СУ ЧАМД ТУСАЛЪЯ төсөл, П.Н.Шастины нэрэмжит Улсын Гуравдугаар Төв Эмнэлгийн Мэдрэл болон Зүрхний мэс заслын тасгийн хүлээлгийн танхимын тохижуулалт, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран Монгол Гэр төсөл зэрэг олон төсөлт хөтөлбөрийг нийгмийн хариуцлагын хүрээнд санаачилж хэрэгжүүлсэн.

3.1. Байгаль орчин

Эрчим хүчний хэрэглээ

Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу цахилгааны хэрэглээг баталгаажсан тоолуураар хэмжиж, сар бүр төлбөр төлдөг бөгөөд тоолуурын бүрэн бүтэн байдлыг хянах, асааж, унтраах, залгах, салгах тухай зааварчилгааг тоолууруудын дэргэд байрлуулсан. Эрчим хүчний хэрэглээг бууруулахын тулд эрчим хүчний зарцуулалт багатай хөргүүр, хөргөгч худалдан авсан бөгөөд дэлгүүр, агуулах, хүнсний үйлдвэрт LED гэрлийн чийдэн суурилуулсан.

LED гэрлийг хэрэглэх нь энгийн улайсдаг гэрэл ашигласнаас эрчим хүчнийг 72-80 хувиар хэмнэдэг гэсэн АНУ-ын эрчим хүч хариуцсан албанаас гаргасан судалгаа байдаг. Эрчим хүчний хэрэглээг бууруулах чиглэлд Компаниас хүчин чармайлт гаргаж ажиллаж байгаа бөгөөд жилд хамгийн багадаа 12,000 кВт эрчим хүч хэмнэж байна. Энэ

үзүүлэлт нь дэлгүүрийн тоо нэмэгдэх тусам улам илүү эерэг нөлөөтэй байна гэж харж байна.

Хог хаягдал

“Өнгө нэм” хог хаягдлын менежмент нэвтрүүлэх хөтөлбөр

Компанийн охин компани Премиум Дистрибьюшн ХХК-ийн хүнсний үйлдвэрлэлээс үүссэн хог хаягдлын хэмжээ, бүтцийн суурь судалгаа болон ажилтан албан хаагчдын хог хаягдлын талаарх ойлголт, хог хаягдлыг бууруулахад хувь хүнээс оруулах хувь нэмэр байгаа эсэх талаарх зан төлөвийн судалгааг Компани “Өнгө нэм” ТББ-тай хамтран хийсэн. Уг судалгаанд тулгуурлан хүнсний үйлдвэрлэлийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулан, ажилтан албан хаагчдыг доорх сургалтуудад хамруулсан.

- Хог хаягдлын талаарх ойлголт
- Хог хаягдлын ангилан ялгалт, хог хаягдлаа зөв хаях соёл
- Хог хаягдлын дахин боловсруулах үйлдвэр

Мөн бүх дэлгүүрүүдэд түр хогийн цэгийг зориулалтын дагуу шийдсэн төдийгүй хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах боломжийг бүрдүүлж, хаягдал батареиг цуглуулах санаачилгыг дэмжин, хэрэгжүүлж байна.

Байгаль орчинд ээлтэй сав баглаа боодол

SU брэнд байгаль орчинд ээлтэй, хог хаягдал багатай сав баглаа боодлыг чухалчлан авч үздэг бөгөөд өөрсдийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг. SU брэнд өөрийн нэрийн GET кофены аягыг дахин боловсруулах бүтэцтэйгээр зах зээлд нэвтрүүлж, байгаль орчинд ээлтэй эко байдлаар шийдсэн. Үүнээс гадна өөрийн аягатай ирээд хөнгөлөлт авч болох үйлчилгээг нэг талаас хэрэглэгчдэд ашигтай, нөгөө талаас байгаль орчинд ээлтэй байхаар бодож нэвтрүүлсэн нь олон хүмүүсийн талархлыг хүлээсэн.



“Гоёлын модны төгөл” ногоон байгууламж

2021 оны 10-р сарын 28-ны өдөр Худалдаа үйлчилгээний салбар үүсэж хөгжсөний 100 жил, Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбар үүсэж хөгжсөний 90 жилийн ойн хүрээнд Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 156 худалдаа, үйлчилгээний байгууллагууд хамтран Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжих “Эрүүл-Эко дүүрэг” зорилтыг дэмжин 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Дөрвөн улирлын цэцэрлэгт хүрээлэн”-д 458 ширхэг мод тарьж, “Гоёлын модны төгөл”-тэй боллоо.



3.2. Нийгэм

Нийгмийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэгч

Аюулгүй, цэвэрхэн орчин бүрдүүлсэн СУ сүлжээ дэлгүүрүүд нь 24 цаг ажилладаг тул шөнийн цагаар орчны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэхээс гадна 24 цагийн харуул хамгаалалт, камержуулалт нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд эергээр нөлөөлж байна.



2021 оны 5-р сараас хүүхэд төөрөх, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “СУ

чамд тусалъя” хүүхэд хамгааллын төслийг санаачлан, хэрэгжүүлж байна. Төслийг бага насны хүүхдүүдэд сурталчлан таниулах зорилгоор Хүүхдийг төөрөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий сонирхолтой буддаг комик номыг эрхлэн гаргаж хүүхдүүдэд үнэгүй тараасан. Энэхүү номд эцэг эхийнхээ хараа хяналтаас холдож болохгүйг анхааруулснаас гадна хэрэв төөрсөн тохиолдолд айж сандралгүй ойр байрлах СУ дэлгүүрт ирэхэд угтан авч аав ээжид нь хүлээлгэн өгч тусална гэсэн санааг агуулсан.

“Монгол гэр төсөл”

Компани нь НҮБ-ын Хүүхдийн сан БНСУ-ын БиЖиЭф Ритэйл компаниудтай хамтран Монгол Улсад хэрэгжүүлэх байгаль орчинд ээлтэй, дулаан алдагдал багатай “Монгол Гэрийн Дулаалгын Төсөл”-ийг хамтран хэрэгжүүлэх албан ёсны санамж бичигт гарын үсэг зурсан.



Төслийн зорилго нь хүүхэд, эмэгтэйчүүд (жирэмсэн эмэгтэйчүүд) болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн агаарын бохирдолтой холбоотой өвчлөлийг бууруулах, тав тухтай дулаахан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, амьдрах орчны чанарыг сайжруулж, ахуйн хог хаягдлыг бууруулах зорилготой бөгөөд гэрт амьдардаг өрхүүдэд цахилгаан халаагуур суурилуулахад дэмжлэг үзүүлэхэд оршиж байгаа юм. Байгальд ээлтэй, дулаан бага алддаг гэр нь цахилгаанаар ажилладаг дулааны системтэй бөгөөд агаарын бохирдолд бага нөлөө үзүүлэхээс гадна энгийн гэртэй харьцуулахад дулаан алдагдлын хэмжээ 25 орчим хувиар бага байдаг. Уг гэр нь эрчим хүчний хэрэглээг бууруулахад маш их нөлөөтэй бөгөөд гал түймэр гарах эрсдэл тун бага байдгаараа онцлогтой.

Хүний нөөц

1000 ажлын байр хөтөлбөр

Компани нь Монгол Улсад цагийн ажил гэх ойлголтыг нутагшуулж өдгөө нийт ажилтнуудын 65-аас дээш хувийг оюутан залуус эзэлж байна. Оюутан залууст хичээлийнхээ хажуугаар байнгын тогтмол орлоготой, уян хатан цагийн хуваарийн дагуу өөрт ойр байршилд ажиллах боломжийг олгодог. Мөн Компани нь хүн бүрд хөдөлмөр эрхлэх тэгш боломжийг нээлттэй олгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар ханган ажилладагаараа үлгэр жишээ бөгөөд нийт ажилтны 4 хувийг тусгай хэрэгцээт ажилтнууд бүрдүүлж байна. Компани нь 2021 оны 11 болон 12-р саруудад шинээр 1,000 ажлын байр бий болгосон.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрны дэмжлэг

Компани нь Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу нийт ажилчдын 4-өөс доошгүй хувийг хөгжлийн бэрхшээлтэй ажилтнаар бүрдүүлэх зорилт тавьж ажилладаг. 2021 онд Сентрал Экспресс Си Ви Эс ХК болон Премиум Дистрибьюшн ХХК-ийн хөгжлийн бэрхшээлтэй ажилтны тоо 73 буюу нийт ажилтны 4 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу богиносгосон цагаар ажилладаг бөгөөд ажлын байрны зарыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй түгээх үүднээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонуудтай идэвхтэй хамтарч ажиллаж байна.

Компанид ажилладаг хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд 50-100 хувийн хөдөлмөрийн чадвар алдалттай бөгөөд дийлэнх нь сонсгол, хараа, хэл ярианы 100 хувь хүртэл бэрхшээлтэй, мөн өнчин тархины хавдар, мэдрэлийн гэмтэл, тохойн зөөлөн эд ясажсан, тулгуур эрхтний гэмтэл, төвхний мултрал, хоёрдогч менингит зэргээс шалтгаалсан

79 хувь хүртэл хөдөлмөрийн чадвар алдсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ажил олгосноор тэдэнд орлогоо нэмэгдүүлэхээс гадна нийгэмд оролцоотой байх, өөрийгөө хөгжүүлэх, ажлын гараа эхлүүлэн карьераа хөгжүүлэх зэрэг зэрэг боломжуудыг эрх тэгш олгож байна. Нөгөө талаас бусад ажилчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ойлгох, хүндлэх, тэдэнтэй зөв зохистой харьцах, тэднийг дэмжин хамтран ажиллаж байна. Ингэснээрээ нийгмийн олон талт, ялгаатай байдлын оролцоо, тэгш боломжийг хангах боломж бүрдүүлж буй нь маш том зэрэг нөлөөлөл юм.

Сургалт хөгжил

Компанийн зүгээс худалдаа, үйлчилгээнийхээ стандартыг өндөр түвшинд байлгах тал дээр ихээхэн анхаардаг. Салбарын онцлогоос шалтгаалан ажилтны шилжилт хөдөлгөөн өндөр байдаг тул шинээр ажилд орсон ажилтныг байгууллагын соёлыг танилцуулах, ойлгуулах, үйлчилгээний соёлыг хэвшүүлэх, эрүүл ахуйн зөв дадалтай болгох, ажлын ур чадвар мэдлэг олгох сургалтуудад хамруулдаг. Сургалтын дараа мэдлэгийг шалгах тест бөглүүлэх бөгөөд 70 хувиас бага үзүүлэлтэй бөглөсөн тохиолдолд тухайн ажилтан давтан сургалтад сурдаг.

Мөн үндсэн ажилчдад зориулж Компанийн үндсэн 7 зарчмын тухай сургалт, хувь хүний хөгжлийн сургалт, манлайллын сургалт, үйлчилгээний соёлын тухай сургалт, дотоод ИТ систем хэрхэн ашиглах тухай сургалт, санхүүгийн менежментийн тухай сургалт, чанар, эрүүл ахуйн тухай, ажлын байранд шаардагдах ур чадвар олгох сургалтууд зэрэг олон төрлийн сургалтыг зохион байгуулдаг.



Түүнчлэн франчайз эрх эзэмшигчдэд зориулж хүний нөөц, ИТ систем, агуулахын менежмент зэрэг чиглэлээр багц хичээл ордог бөгөөд ингэснээр франчайз дэлгүүрүүдийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанар Компаниас мөрддөг нэгдсэн стандарт, загварын дагуу явагдах нөхцөлийг бүрдүүлдэг. Ковид-19 цар тахал гарч, хөл хорио дэглэм тогтоосонтой уялдуулан онлайн сургалтын

контентууд бэлдэж Компанийн дотоод платформд байрлуулсан бөгөөд сургалтын материалууд нь ойлгомжтой, сонирхолтой байдлаар бэлтгэгдсэн. 2021 онд Сентрал Экспресс Си Ви Эс ХК болон Премиум Дистрибьюшн ХХК-ийн ажилчдад нийт 186,000 хүн цагийн сургалт орсон.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент

Компанийн зүгээс ХАБЭА-н зөв хандлага, соёл бүрдүүлж, салбартаа үлгэр жишээ үйлчилгээний байгууллага байхад анхаарч үйл ажиллагаагаа тогтмол сайжруулж ажилладаг. Компани болон Премиум Дистрибьюшн ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой журам, заавар, зааварчилгааг нягт баримтлан мөрдөж ажилладаг. 2021 онд ажлын байран дээрх осол гэмтэлгүй нийт 1.68 сая хүн цаг гэсэн сайн үзүүлэлттэй ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрсдэлийн албанаас ажилтнуудыг тогтмол сургалтад хамруулж, мэдээлэл өгч байна.

Ковид-19 цар тахлын эсрэг арга хэмжээ

Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлж ажилтны эрүүл мэнд дархлааг дэмжих зорилгоор Компаниас амин дэм, витаминаар баялаг хоол хүнс, амны хаалт, бээлий, ариутгалын бодисоор ажилчдыг хангасан. Мөн салбар дэлгүүрүүдэд кассын урдуур тусгаарлагч хийж үйлчлүүлэгчид болон ажилчдын аюулгүй байдлыг ханган ажилласан.

Дэлгүүр, хоол үйлдвэрлэлийн төв, түгээлтийн төвд ариутгал цэвэрлэгээ үйлчилгээ болон хортон шавж устгал, ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол давтамжтайгаар тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагуудаар хийлгэн хяналт тавин ажилласан бөгөөд нийт ажилтнуудаа вакцинжуулалтын 1, 2-р тунд хамруулж 3, 4-р тунд хамрагдахыг уриалан ажилласан.

Тогтвортой худалдан авалт

Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Гүйцэтгэлийн стандарт #3: Нөөцийн үр ашигтай байдал, бохирдлоос сэргийлэх, Монголын хөрөнгийн биржид нэвтрүүлэхээр хэлэлцэж буй БОНЗ-ын тайлагналын үзүүлэлтийн дагуу Сентрал Экспресс Си Ви Эс ХК-ийн худалдан авалтын үйл ажиллагаанд үнэлгээ хийсэн. Компанийн хувьд дотоодын бэлтгэн нийлүүлэгчдийг дэмжих бодлого баримталж ажилладаг бөгөөд 2018 оны 9-р сард баталсан Худалдан авалтын үйл ажиллагааны журамд худалдан авалт хийхдээ баримтлах 4 үндсэн зарчмыг тодорхойлсон. Үүнд:

- **Ёс зүйн зарчим:** Монгол Улсын хууль дүрэм журмыг чандлан мөрдөнө. Ашиг сонирхлын аливаа зөрчлөөс ангид байна, үнэнч шударгаар ажиллана.
- **Эдийн засгийн зарчим:** Бараа, үйлчилгээний үнэ, чанар, бэлтгэн нийлүүлэгчийн найдвартай байдал, хэмнэлттэй, шуурхай нийлүүлэх зэрэг эдийн засгийн үр ашгийг харгалзаж үзнэ.
- **Шударга, ил тод байх зарчим:** Бараа, үйлчилгээг нийлүүлэх боломжтой бүхий л бэлтгэн нийлүүлэгчид нээлттэй шударга, ил тод байдлаар, тэгш өрсөлдөх боломжийг олгоно.
- **Нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлэх зарчим:** Нэн тэргүүнд улс орныхоо хөгжилд дэмжлэг үзүүлэх, байгаль орчинд ээлтэй, сөрөг нөлөөгүй, эрчим хүчний хэмнэлттэй, дахин боловсруулан ашиглах боломжтой бараа, үйлчилгээг сонгож худалдаж авна гэж заасан.

4. Компанийн засаглалын тайлан

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (“Компани”)–ийн засаглалын бүтэц нь Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн, үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, дотоод хяналт, эрсдэлийг зөв зохистой удирдах, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байдаг.

Компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон олон улсад танигдсан шилдэг туршлага, зарчмуудыг баримталж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд сайн засаглал нь бизнесийн стратегийг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах, бизнесийн ёс зүй, ил тод, шударга байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн үздэг.

4.1. Хувьцаа эзэмшигчид

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК нь олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох албан ёсны зөвшөөрлөө 2021 оны 10-р сарын 13-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооноос авсан бөгөөд 2021 оны 11-р сарын 03-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн III дугаар ангиллаар нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч арилжаагаа амжилттай дуусгаж, 2021 оны 11-р сарын 12-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаагаа нээснээр нээлттэй хувьцаат компани болсон. 2022 оны 3-р сарын байдлаар Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны тоо 817,768,643, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо 9,506 байгаа бөгөөд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо	Эзэмшиж буй хэмжээ
А.Ганхуяг	238,117,485	29.1%
А.Ганболд	172,327,784	21.1%
Ц.Баяржаргал	88,164,258	10.8%
БиЖиЭф Ритэйл	67,980,767	8.3%

2021 оны санхүүгийн жилд Компанийн тухай хуульд заасны дагуу шаардах эрхээ хэрэгжүүлэн хувьцаа худалдсан хувьцаа эзэмшигч байхгүй болно.

Хувьцаа эзэмшигчдийн эрх

Компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхээ хэрэгжүүлэх гол хэлбэр нь Хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Компанийн тухай хууль болон Компанийн Дүрмийн холбогдох заалтуудын дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлдэг.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)–өөс Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журмыг баталсан бөгөөд тус журмаар Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах, хурлын мэдээллийг хүргэх, хурлыг хуралдуулах болон хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах, хувьцаа эзэмшигчид хуралд оролцох, саналаа өгөх эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулдаг.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай санал, шаардлагыг саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч нь ТУЗ-д гаргаж болно. ТУЗ нь шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтаан шийдвэр гаргаагүй тохиолдолд шаардлага гаргасан хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай шийдвэрийг бие даан гаргаж болно.

Компани нь олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох албан ёсны зөвшөөрлөө 2021 оны 10-р сарын 13-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос авч улмаар Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу 2021 оны 12-р сарын 28-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд тус хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 83.9 хувь нь оролцож дараах үндсэн 4 асуудлыг хэлэлцэн баталсан.

1. Компанийн хэлбэрийг өөрчлөх;
2. Компанийн албан ёсны хаягийг өөрчлөх;
3. Компанийн дүрмийг батлах; болон
4. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох.

Компани нь хувьцаа эзэмшигчдийнхээ эрхийг хангах үүднээс Компанийн Хувьцаа

эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэсэн бөгөөд хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах, <https://hural.cumongol.mn> веб хаягаар урьдчилан санал өгөх боломжоор хангасан. Мөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд ТУЗ-ийн бүх гишүүд болон Гүйцэтгэх удирдлага оролцож хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулт, тодруулга өгсөн.

Мэдээлэл хүргэх

Компани нь хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, бусад оролцогч талуудад мэдээллийг олон эх сурвалжаар, нэгэн зэрэг, ил тод хүргэх нь хувьцаа эзэмшигчдийн итгэлийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагчдад Компанийн үйл ажиллагаа болон бизнесийн стратегийн талаар үнэн зөв, бодит ойлголтыг өгөхөд чухал үүрэгтэй хэмээн үздэг.

Компани нь өөрийн цахим хуудас, Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу хэвлэн нийтлэх, болон тухайн мэдээллийг сонирхогч этгээд саадгүй авах боломжийг хангасан бусад хэлбэрээр мэдээллийг цаг тухайд нь хүргэж байна.

Компани нь өөрийн цахим хуудсанд хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд зориулсан тусгай цэсийг бий болгосон бөгөөд тухайн цэсэд Компанийн бүтэц зохион байгуулалт, засаглал, ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүн, Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой мэдээ мэдээлэл, Компанийн жилийн, хагас жилийн, улирлын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны тайлан, үнэт цаасны ханшийн мэдээ зэрэг мэдээ, мэдээллийг багтаасан бөгөөд мэдээлэлд өөрчлөлт орох бүрд нь шинэчлэн ажиллаж байна.

Ногдол ашгийн журам

Компанийн ТУЗ-өөс Ногдол ашгийн журмыг баталсан бөгөөд тус журам нь Компанийн ногдол ашгийн бодлогын баримт бичиг болох бөгөөд хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, ногдол ашиг хуваарилах нөхцөлийг тодорхойлох, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах, ногдол ашиг хуваарилах, мэдээлэх, тайлагнахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

2021 онд Компани алдагдалтай ажилласан тул Үнэт цаасны танилцуулгад тусгасан төлөвлөгөөний дагуу Компанийн ТУЗ-өөс 2022 оны 02-р сарын 18-ны өдрийн 3 тоот тогтоолоор 2021 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

4.2. Төлөөлөн удирдах зөвлөл

ТУЗ нь хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудад урт хугацааны үнэ цэнийг бий болгох зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлсэн үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлж, хяналт тавин ажилладаг. ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд эдгээр гишүүдийн 6 нь ердийн, 3 нь хараат бус гишүүд юм.

ТУЗ-ийн ердийн гишүүдэд:

1. Адилбиш овогтой Ганхуяг, ТУЗ-ийн дарга бөгөөд Нэр дэвшүүлэх хорооны дарга
2. Адилбиш овогтой Ганболд, ТУЗ-ийн гишүүн бөгөөд Цалин урамшууллын хорооны дарга
3. Гансүх овогтой Бат-Эрдэнэ, ТУЗ-ийн гишүүн бөгөөд Аудитын хорооны гишүүн
4. Очирбат овогтой Батмөнх, ТУЗ-ийн гишүүн бөгөөд Байгаль орчин, нийгэм, засаглалын хорооны гишүүн
5. Ганболд овогтой Чинзориг, ТУЗ-ийн гишүүн бөгөөд Гүйцэтгэх захирал
6. Болдбаатар овогтой Бат-Эрдэнэ, ТУЗ-ийн гишүүн бөгөөд Байгаль орчин, нийгэм, засаглалын хорооны гишүүн

ТУЗ-ийн хараат бус гишүүдэд:

1. Нямжав овогтой Энхболд, ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хорооны гишүүн
2. Чулуун овогтой Мэргэн, ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх хорооны гишүүн
3. Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo), ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд Байгаль орчин, нийгэм, засаглалын хорооны дарга, Цалин урамшууллын хороо болон Аудитын хорооны гишүүн

ТУЗ-ийн гишүүдийг томилох, улируулан сонгох, чөлөөлөх

Компанийн Дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байна. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүдийг томилох, бүрэн эрхийг тогтоох болон хугацаанаас нь өмнө дуусгавар болгох асуудлуудыг шийдвэрлэх бөгөөд ТУЗ-ийн гишүүдийг санал хураах кумулятив аргаар сонгоно. ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгож болох бөгөөд улируулан сонгохоор нэр дэвшүүлэхдээ тухайн этгээдийг нэр дэвшүүлсэн үндэслэл болон ТУЗ-ийн хуралд оролцсон ирц, ажлын гүйцэтгэлийг хянаж үзнэ.

Удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл ТУЗ түр томилж болно.

ТУЗ-ийн гишүүдийн сургалт, хөгжил

Компани нь ТУЗ-ийн гишүүнийг шинээр томилогдох бүрд Компанийн санхүүгийн тайлагнал, бизнесийн онцлог болон үйл ажиллагаа, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, хариуцлага зэрэг мэдээллийг агуулсан танилцах хөтөлбөрт хамруулдаг.

2021 оны 11-р сарын 01-ний өдөр Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбоо, Корпорацийн санхүү, эдийн засаг, эрх зүй судлалын төвөөс хамтран зохион байгуулсан Компанийн засаглалын ахисан түвшний мэдлэгийг гэрчлэн баталгаажуулах дээд эрэмбийн сургалтад Компанийн ТУЗ-ийн гишүүд болон эрх бүхий албан тушаалтнууд хамрагдсан бөгөөд тус сургалт нь (i) Нээлттэй компанийн мэдээлэх үүрэг мэдээллийн ил тод байдал; (ii) Монгол улсын үнэт цаасны зах зээл дэх дотоод мэдээлэлд тооцогдох мэдээллүүд, дотоод мэдээлэл эзэмшигчийн үүрэг хариуцлага; (iii) Санхүүгийн зохицуулах хорооны хяналт; (iv) Монголын хөрөнгийн бирж; (v) ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Комплаинс; (vi) Компанийн эрх бүхий албан тушаалтан; болон (vii) Чухал хэлцэл гэсэн үндсэн 7 сэдвийн хүрээнд явагдаж оролцогчдод гэрчилгээ олгосон.

2021 оны 11-р сарын 20-ны өдөр Компанийн Гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-ийн гишүүдэд зориулан (i) Компанийн үндсэн үйл ажиллагаа, бизнесийн стратеги, бодлого, зорилт, дэд бүтэц, эрсдэл, тулгамдаж буй асуудлууд; (ii) Компанийн засаглал, бүтэц зохион байгуулалт; болон (iii) Компани нь

нээлттэй хувьцаат компани болж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор дагаж мөрдөх холбогдох хууль, тогтоомж, журмын танилцуулга гэсэн агуулга бүхий Компанийн тухай танилцуулгыг хийсэн бөгөөд ТУЗ-ийн бүх гишүүд хамрагдсан.

ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал

2021 оны санхүүгийн жилд ТУЗ-ийн гишүүдэд цалин урамшуулал олгоогүй бөгөөд Гүйцэтгэх удирдлагад олгосон цалин урамшууллын нийт хэмжээ нь 726,708,634 төгрөг байна.

ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын Компанид эзэмшиж буй хувьцааны тооны мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын эзэмшиж буй хувьцаа

ТУЗ-ийн гишүүний нэр	Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо	Эзэмшиж буй хэмжээ
А.Ганхуяг	238,117,485	29.1%
А.Ганболд	172,327,784	21.1%
О.Батмөнх	20,001,751	2.4%
Г.Бат-Эрдэнэ	19,778,691	2.4%
Г.Чинзориг	44,150	0.005%
Б.Бат-Эрдэнэ	80,000	0.01%
Н.Энхболд	961,538	0.12%

2021 оны санхүүгийн жилийн байдлаар дээрх хүснэгтэд дурдсан ТУЗ-ийн гишүүдээс бусад ТУЗ-ийн гишүүд Компанид хувьцаа эзэмшдэггүй болно.

ТУЗ-ийн хороод

Компанийн ТУЗ нь 2021 оны 12-р сарын 28-ны өдөр ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо болон Байгаль орчин, нийгэм, засаглалын хороог тус тус байгуулж хороодын дарга болон гишүүдийг томилсон. Мөн ТУЗ-ийн дөрвөн хороодын үйл ажиллагааны журмыг баталсан ба журмуудыг Компанийн цахим хуудаст байршуулсан бөгөөд аливаа сонирхогч этгээдийн хүсэлтээр танилцуулж болно.

Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо

Байгаль орчин, нийгэм, засаглал ("БОНЗ")-ын хороо нь ТУЗ-ийн ердийн гишүүд болох О.Батмөнх, Б.Бат-Эрдэнэ болон ТУЗ-ийн хараат бус гишүүн Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нараас бүрдсэн 3 гишүүнтэй бөгөөд Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нь тус хорооны дарга юм.

БОНЗ-ын хороо нь (i) БОНЗ-ын алсын хараа, стратеги, бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд хяналт тавих; (ii) БОНЗ-ын шинээр гарч ирж буй чиг хандлага, асуудлуудыг хянаж үзэх, үүний дагуу Компанийн БОНЗ-ын талаарх алсын харааг боловсруулах, заавар зөвлөмжийг өгөх; (iii) аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, нийгмийн хариуцлага, компанийн засаглалын талаарх Компанийн бодлогыг тодорхойлох, түүнд шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах; болон (iv) ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын сургалт, тасралтгүй мэргэшлийн өсөлтөд хяналт тавих, хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөх бодлого, журам, гарын авлага, ёс зүйн дүрмийг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хянах, ТУЗ болон түүний хороодын үйл ажиллагаа, ТУЗ-ийн гишүүдийн оруулсан хувь нэмрийг тогтмол үнэлж, ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй.

Аудитын хороо

Аудитын хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Мэргэн, хорооны гишүүдээр ТУЗ-ийн ердийн гишүүн Г.Бат-Эрдэнэ болон хараат бус гишүүн Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нар ажиллаж байна.

Аудитын хороо нь Компанийн санхүүгийн тайлан гаргах ажиллагаа, аудитын үйл ажиллагаа, холбогдох хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд Компанийн зүгээс тавих хяналтын үйл ажиллагааны дахин хянан нягталж энэхүү үйл ажиллагааны үр дүнг үндэслэн ТУЗ-д зөвлөмж гаргах, дотоод болон хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг баталгаажуулах, ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлага ба дотоод болон хөндлөнгийн аудиторчуудын үр ашигтай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ. Аудитын хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна:

- Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

- дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;
- аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах; болон
- их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах.

Нэр дэвшүүлэх хороо

Нэр дэвшүүлэх хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд хорооны даргаар ТУЗ-ийн дарга А.Ганхуяг, хорооны гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүд Н.Энхболд болон Ч.Мэргэн нар ажиллаж байна.

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх, Компанид шаардлагатай мэдлэг, ур чадвартай удирдах ажилтныг олж тогтоож, улмаар Компанийг бизнесийн зорилтдоо хүрэх, бизнесээ тогтвортой хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хүний нөөцийн урт болон богино хугацааны төлөвлөлтийг боловсруулж, дүгнэлт гарган ТУЗ-д танилцуулах үүрэгтэй.

Цалин урамшууллын хороо

Цалин урамшууллын хороо нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд хорооны даргаар ТУЗ-ийн ердийн гишүүн А.Ганболд, гишүүдээр ТУЗ-ийн хараат бус гишүүд Н.Энхболд болон Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нар ажиллаж байна.

Цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал, нөхөн олговортой холбоотой зохицуулалтыг тодорхойлох, хяналт тавих, өндөр ур чадвартай ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг урт хугацаанд хадгалж ажиллуулах замаар хувьцаа эзэмшигчдийн ашгийг их байлгах ерөнхий зорилгын хүрээнд эдгээр эрх бүхий албан тушаалтнуудын урамшууллын хэлбэр, хэмжээ нь зохистой байгаа эсэхийг хөдөлмөрийн зах зээлийн холбогдох нөхцөл байдалд үндэслэн үнэлэх үүрэгтэй юм.

ТУЗ-ийн үйл ажиллагаа

Компани нь Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг баталсан бөгөөд тус журам болон холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу үйл ажиллагаа явуулж байна.

ТУЗ нь холбогдох хууль, тогтоомж эсвэл Компанийн Дүрэмд заасан Хувьцаа эзэмшигчдийн бүрэн эрхэд хамаарах асуудлаас бусад Компанийг стратеги удирдлага, тогтвортой хяналтаар үр дүнтэй хангахад шаардлагатай бүхий л үйл ажиллагааг явуулах бүрэн эрхтэй бөгөөд хувьцаа эзэмшигчдэд урт хугацааны үнэ цэнийг бий болгох, оролцогч талуудын эрх ашгийг хангах зорилго бүхий үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Тайлант хугацаанд Компанийн ТУЗ нь 4 удаа хуралдсан бөгөөд эдгээр хуралд ТУЗ-ийн гишүүд бүгд оролцож, хурлын ирц 100 хувьтай байсан.

5. Санхүүгийн тайлангууд

Нэгтгэсэн орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлан, мянган төгрөгөөр

	2021	2020
Харилцагчидтай байгуулсан гэрээний орлого	94,038,017	45,348,032
Борлуулалтын өртөг	(100,906,088)	(50,706,836)
Нийт алдагдал	(6,868,071)	(5,358,804)
Ерөнхий, захиргааны болон борлуулалтын зардал	(7,854,845)	(5,102,425)
Бусад олз/(гарз), цэвэр дүнгээр	689,059	(33,610)
Бусад орлого	250,167	-
Үйл ажиллагааны алдагдал	(13,783,689)	(10,494,839)
Санхүүгийн зардал	(5,700,493)	(5,588,408)
Санхүүгийн орлого	1,429,902	159,415
Орлогын албан татварын өмнөх алдагдал	(18,054,280)	(15,923,832)
Орлогын албан татварын зардал	(11,496)	195,737
Тайлант жилийн алдагдал	(18,065,778)	(15,728,095)
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй ашиг	-	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	(18,065,778)	(15,728,095)
Компанийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах нэгж энгийн хувьцаанд ногдох үргэлжилж буй үйл ажиллагааны суурь болон хорогдуулсан ашиг (алдагдал), (нэгж хувьцаанд ногдох төгрөг)	(37.78)	(91.73)

4.3. Эрсдэлийн удирдлага болон дотоод хяналт

Компанийн тодорхойлсон гол эрсдэлүүд, тэдгээрийн нөлөө, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн талаарх мэдээллийг "Гүйцэтгэх удирдлагын тайлан, Эрсдэлийн хүчин зүйлс ба удирдлага" хэсгээс харна уу.

Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, мянган төгрөгөөр

	2021	2020
Үндсэн хөрөнгө	40,471,007	17,916,171
Ашиглах эрхтэй хөрөнгө	22,599,622	16,813,036
Санхүүгийн түрээсийн авлага	4,092,438	2,062,987
Биет бус хөрөнгө	2,909,300	2,808,115
Гүүдвил	2,818,907	-
Бусад авлага	1,075,318	404,800
Бусад эргэлтийн бус хөрөнгө	415,869	369,717
Хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгө	279,073	240,809
Нийт эргэлтийн бус хөрөнгө	74,661,534	40,615,635
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	14,861,351	-
Бараа материал	14,072,543	6,710,974
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4,061,156	6,104,077
Урьдчилгаа төлбөр	2,926,557	1,844,388
Дансны ба бусад авлага	2,419,423	1,469,744
Зээлийн авлага	2,016,877	-
Санхүүгийн түрээсийн авлага	453,435	171,821
Нийт эргэлтийн хөрөнгө	40,811,341	16,301,004
Нийт хөрөнгө	115,472,875	56,916,639
Хувьцаат капитал	81,776,864	17,145,256
Нэмж төлөгдсөн капитал	13,820,503	-
Хуримтлагдсан алдагдал	(51,591,071)	(33,525,294)
Нийт эзэмшигчдийн өмч	44,006,296	(16,380,038)
Урт хугацаат түрээсийн өр төлбөр	26,918,102	19,570,737
Урт хугацаат зээл	14,411,323	10,520,000
Бусад урт хугацаат өр төлбөр	89,444	-
Нийт урт хугацаат өр төлбөр	41,418,869	30,090,737
Дансны ба бусад өглөг	22,665,543	24,320,649
Түрээсийн өглөг	3,807,028	1,627,744
Зээл	2,077,020	16,360,739
Урьдчилж олсон орлого	973,614	457,164
Бусад татварын өглөг	474,627	439,644
Тайлант жилийн орлогын албан татварын өглөг	49,878	-
Нийт богино хугацаат өр төлбөр	30,047,710	43,205,940
Нийт өр төлбөр	71,466,579	73,296,677

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, мянган төгрөгөөр

	2021	2020
Орлогын албан татварын өмнөх алдагдал	(18,054,281)	(15,923,832)
<i>Тохируулгууд:</i>		
Үндсэн хөрөнгийн элэгдэл	5,182,885	3,048,671
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	30,992	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	29,913	76,645
Биет бус хөрөнгийн хорогдуулга	544,890	454,885
Бараа материал данснаас хассаны гарз	3,571,046	26,870
Найдваргүй авлагын зардал	145,538	1,052
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	3,624,673	1,823,177
Гадаад валютын ханшийн зөрүү	52,740	145,819
Санхүүгийн орлого	(1,429,902)	(159,415)
Санхүүгийн зардал	5,700,493	5,716,607
Ашиглах эрхтэй хөрөнгө данснаас хассаны олз	(706,646)	(234,568)
Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	(1,307,659)	(5,024,089)
Дансны ба бусад авлагын өсөлт	(477,454)	(654,374)
Бараа материалын өсөлт	(10,525,886)	(2,713,153)
Дансны ба бусад өглөгийн өсөлт	14,989,550	17,331,645
Урьдчилгаа төлбөрийн өсөлт	(1,726,873)	(977,941)
Бусад татварын өглөгийн бууралт	(49,719)	(77,196)
Урьдчилж олсон орлогын өсөлт	516,450	410,500
Ажлын капиталын өөрчлөлтийн дараах үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	1,418,409	8,295,392
Зээлийн хүүгийн төлөлт	(1,770,685)	(2,240,343)
Орлогын албан татварын төлөлт	(19,790)	(45,072)
Санхүүгийн түрээсийн өглөгийн хүү төлөлт	(3,987,607)	(2,974,883)
Хүлээн авсан хүүгийн орлого	573,856	159,415
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(3,785,817)	3,194,509
Худалдаж авсан үндсэн хөрөнгө	(13,739,877)	(7,951,042)
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	25,863	174,232
Худалдаж авсан биет бус хөрөнгө	(542,004)	(353,020)
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	3,251
Санхүүгийн түрээсийн авлагаас хүлээж авсан орлого	338,880	571,097
Бизнесийн нэгдлээр авсан охин компанийн цэвэр мөнгөн хөрөнгө	242,776	-
Холбоотой талуудад олгосон зээл	(2,000,000)	-
Худалдаж авсан өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	(14,700,000)	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(30,374,362)	(7,555,480)

	2021	2020
...		
Гаргасан хувьцаа	29,616,600	-
Авсан зээл	5,192,725	13,787,912
Санхүүгийн түрээсийн төлөлт	(2,122,067)	(717,602)
Зээлийн эргэн төлөлт	(570,000)	(3,241,964)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	32,117,258	9,828,346
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөд үзүүлэх гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	-	(14,780)
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)	(2,042,921)	5,467,373
Тайлант жилийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,104,077	651,484
Тайлант жилийн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,061,156	6,104,077

6. Хавсралт



Хараат бус аудиторын тайлан

Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК-ийн ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр, Сэнтрал Экспресс Си Ви Эс ХК (цаашид "Компани" гэх) болон түүний охин компаниуд (хамтад нь "Групп" гэх)-ын нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн үр дүн, нэгтгэсэн болон тусдаа мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бодитойгоор илэрхийлэгдсэн байна.

Бид юунд аудит хийсэн талаар

Дараах бүрэлдэхүүн бүхий Группийн нэгтгэсэн болон Компанийн тусдаа санхүүгийн тайлангуудад бид аудитыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн байдлын тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн болон тусдаа орлого үр дүнгийн болон бусад орлогын дэлгэрэнгүй тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн болон тусдаа өмчийн өөрчлөлтийн тайлан;
- тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн нэгтгэсэн болон тусдаа мөнгөн гүйлгээний тайлан; болон
- нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд болон бусад тайлбар мэдээллээс бүрдсэн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудын тодруулгууд.

Дүгнэлтийн үндэс

Бид Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу аудитын ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагын талаар тус тайлангийн Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт тусгасан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болсон гэдэгт бид итгэлтэй байна.

Хараат бус байдал

Нягтлан бодогчдын олон улсын ёс зүйн стандартын зөвлөл (НБОУЭСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (МНБЭЗД)-ийн (Хараат бус байдлын олон улсын стандартыг оруулан) дагуу Группээс бид хараат бус болно. Бид МНБЭЗД-ийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

ПрайвотерхаусКуперс Аудит ХХК, Сэнтрал Тауэр, 6 давхар, 601 тоот,
Сүхбаатарын талбай, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Улаанбаатар хот 14200, Монгол улс
Утас: +976 70009089, Факс: +976 (11)322068, www.pwc.com/mn



Аудитын арга барил

Хураангуй



Материаллаг байдлын түвшин

- Группийн материаллаг байдлын ерөнхий түвшин: 940 сая төгрөг бөгөөд нийт орлогын 1 хувьтай тэнцүү.
- Компанийн материаллаг байдлын ерөнхий түвшин: 940 сая төгрөг бөгөөд нийт орлогын 1 хувьтай тэнцүү.

Группийн хамрах хүрээ

- Группийн аудитын цар хүрээ нь Компани болон нэг охин компанийн аудитын ажлыг хамарсан.
- Аудитын цар хүрээ нь Группийн орлогын 100%, Группийн татварын өмнөх алдагдлын 100%-д үндэслэсэн.

Аудитын гол асуудлууд

- Нийтлэг хяналтан дор бизнесийн нэгдлийн нягтлан бодох бүртгэлийн хандлага

Бид энэхүү материаллаг байдлын түвшинг тодорхойлж, нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудад материаллаг буруу илэрхийлэл байх эрсдэлийг тооцооны үндсэн дээр аудитаа төлөвлөсөн. Тухайлбал, бид удирдлагын хийсэн томоохон тооцоолуудыг авч үзсэн бөгөөд үүний нэг жишээ нь тодорхой бус ирээдүйн үйл явдлын талаарх таамаглалыг агуулсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллууд юм. Бид хийсэн аудитынхаа бүх хүрээнд бусад асуудлууд дотор гүйцэтгэх удирдлагын эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих үйлдлүүд болон залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг батлах нотолгоо байгаа эсэхийг авч үзсэн.

Бид аудитын цар хүрээгээ Группийн бүтэц, үйл ажиллагаа эрхэлдэг салбар, бүртгэл хөтлөлт болон хяналтын системийг багтаан санхүүгийн тайлангуудыг бүхэлд нь дүгнэхэд хангалттай нотолгоо өгөхүйц, бидэнд үр дүнтэй ажиллах боломж олгох байдлаар тодорхойлсон.

Материаллаг байдал

Бидний аудитын цар хүрээнд материаллаг байдал мөн нөлөөлдөг ба аудит нь нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангууд бүхэлдээ материаллаг буруу илэрхийллээс ангид гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахад зориулагдсан. Буруу тайлагнал нь алдаа эсвэл залилангаас үүсч болох бөгөөд энэ нь тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр байвал материаллаг хэмээн тооцогдоно.

Бид өөрсдийн мэргэжлийн үнэлэмжинд үндэслэн Групп болон Компанийн нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудад бүхэлд нь хамаарах материаллаг байдлын ерөнхий түвшинг тогтоосныг доорх хүснэгтэнд харуулав. Эдгээрийг чанарын бусад хүчин зүйлсийн хамт харгалзаж үзсэнээр бид аудитын гүйцэтгэх хугацаа, горимуудын цар хүрээг тогтоож буруу илэрхийлэл байгаа бол тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудад бүхэлдээ хэрхэн нөлөөлөхийг тодорхойллоо.



Аудитын арга барил (үргэлжлэл)

Группийн материаллаг байдлын ерөнхий түвшин	940,000 мянган төгрөг
Компанийн материаллаг байдлын ерөнхий түвшин	940,000 мянган төгрөг
Тодорхойлохдоо ашигласан арга	Нийт орлогын 1 хувь
Материаллаг байдлын түвшинг тооцсон үндэслэл	Бидний үзэж байгаагаар, орлогын нийт дүн нь хэрэглэгчдийн хувьд Групп болон Компанийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хамгийн түгээмэл хэмждэг жишиг буюу энэ нь нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн жишиг үзүүлэлт юм. Бидний сонгосон 1 хувь нь энэ салбар дахь ашиг олох зорилготой, ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын хувьд хүлээн зөвшөөрөгдөх материаллаг байдлын түвшинтэй нийцэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд гэдэг нь бидний мэргэжлийн үнэлэмжийн хувьд тухайн тайлант хугацааны нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудын аудитад хамгийн чухал нөлөө үзүүлсэн зүйлсийг хэлнэ. Эдгээр асуудлуудыг бид нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудыг аудитлах явцдаа болон аудитын дүгнэлт өгөхдөө харгалзан үздэг бөгөөд тусад нь нэмэлт дүгнэлт гаргадаггүй болно.

Аудитын гол асуудлууд	Бидний гүйцэтгэсэн аудит эдгээр асуудлуудыг хэрхэн авч үзсэн тухай
<p>Нийтлэг хяналт бүхий бизнесийн нэгдлийн нягтлан бодох бүртгэлийн бодлого</p> <p>Санхүүгийн тайлангуудын Тодруулга 4, 11 болон 35-аас харна уу.</p> <p>Групп 2021 оны 6 дугаар сарын 8-ны өдөр Сентрал Экспресс Си Ви Эс ХК-ийн өмнөх эцсийн толгой компани болох Премиум Групп ХХК-аас Премиум Дистрибьюшн ХХК-ийн эзэмшлийн 100%-ийг худалдан авсан.</p> <p>Группийн удирдлага СТОУС 3, Бизнесийн нэгдэл дэх бизнесийн тодорхойлолтод үндэслэн энэхүү ажил гүйлгээг нийтлэг хяналт бүхий бизнесийн нэгдэл гэж ангилж, худалдан авалтын аргыг ашиглан хүлээн зөвшөөрсөн.</p> <p>Премиум Дистрибьюшн ХХК-ийн өмнөх хувьцаа эзэмшигчдэд 7,724,396 мянган төгрөгийг төлбөрийг Компанийн энгийн хувьцаа хэлбэрээр төлсөн.</p> <p>2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бизнесийн нэгдлийн бодит үнэ цэнийн үнэлгээ тайлант хугацааны эцэст дуусаагүй байсан тул Групп худалдан авсан хөрөнгө, өр</p>	<p>Аудитын гол асуудлыг шийдвэрлэхийн тулд бидний гүйцэтгэсэн аудитын горимууд нь дараах зүйлсээс бүрдэнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1) Премиум Дистрибьюшн ХХК-ийн худалдан авалтыг хүлээн зөвшөөрөхөд ашигласан Группийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын үндэслэлтэй байдлын үнэлэх. 2) Премиум Дистрибьюшн ХХК-ийн худалдан авсантай холбоотой эрх зүйн баримт бичгүүдийг хянан шалгах. 3) Премиум Дистрибьюшн ХХК-ийн худалдан авсны үр дүнд хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгө, өр төлбөрийн урьдчилсан тооцоо болон бодит үнэ цэнийн үндэслэлтэй байдлыг үнэлэх. 4) Премиум Дистрибьюшн ХХК-ийн худалдан авсантай холбоотой үүссэн гүүдвиллийн тооцоо үнэн зөв эсэхийг шалгах, энэ нь өмнөх хувьцаа эзэмшигчид төлсөн төлбөр болон шинээр худалдан авсан хөрөнгө, өр төлбөрийн урьдчилан



Аудитын арга барил (үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)	Бидний гүйцэтгэсэн аудит эдгээр асуудлуудыг хэрхэн авч үзсэн тухай (үргэлжлэл)
<p>төлбөрийн үнэ цэнийг урьдчилан байдлаар тооцоолсон.</p> <p>Бид нийтлэг хяналт бүхий бизнесийн нэгдлийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын нарийн төвөгтэй байдал болон материаллаг байдлын ерөнхий түвшингээс шалтгаалан үүнд анхаарлаа хандуулсан.</p>	<p>тооцоолсон үнэ цэнэ болон бодит үнэ цэнийн зөрүү юм.</p> <p>5) Премиум Дистрибьюшн ХХК-ийг худалдан авсан талаарх тайлбар, нөлөө бүхий үнэлэмж болон тэдгээрийн зохистой, бүрэн байдлын мэдээллийг тусгасан нягтлан бодох бүртгэлийн тодруулгуудыг СТОУС-д нийцэж байгаа эсэхийг нягтлан шалгах.</p>

Группийн аудитын цар хүрээг бид хэрхэн тодорхойлсон талаар

Бид аудитын цар хүрээгээ Группийн бүтэц, үйл ажиллагаа эрхэлдэг салбар, бүртгэл хөтлөлт болон нягтлан бодох системийг багтаан нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бүхэлд нь дүгнэхэд хангалттай нотолгоо өгөхийг, бидэнд үр дүнтэй ажиллах боломж олгох байдлаар тодорхойлсон.

Бид Группийн бүтцийг харгалзан 2021 оны аудитын цар хүрээг тодорхойлж, төлөвлөсөн. Групп нь Монгол Улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулдаг Компани болон түүний охин компаниас бүрддэг. Эдгээр аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн мэдээллийг Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тусгасан болно.

Бид 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Группийн нийт орлогын 100 хувийг хамарсан ажилд аудитын горимоо хэрэгжүүлсэн.

Гүйцэтгэсэн горимууд нь Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авах боломжийг бидэнд олгож, аудитын дүгнэлт гаргах үндэслэл болсон.

Бусад мэдээлэл

Бусад мэдээллийн хүрээнд удирдлага хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн хугацааны Жилийн тайлангаас бүрдэх боловч бидний аудитын тайлан болон нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудыг агуулаагүй байдаг. Жилийн тайланг энэхүү аудиторын тайланг гаргах өдрийн өмнө бид хүлээн авсан.

Бидний нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудад өгөх дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй тул бид бусад мэдээлэлд аливаа төрлийн баталгаа болон дүгнэлт өгдөггүй.

Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой үүрэг хариуцлагынхаа хүрээнд бид, дээр дурдсан бусад мэдээллийг уншиж танилцаад түүнд нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудтай болон бидний аудитын явцад олж авсан мэдэгдэхүүнтэй материаллаг байдлын түвшинд авцалдаагүй, материаллаг хэмжээний буруу илэрхийлэл агуулж буй эсэхийг авч үздэг.

Гүйцэтгэсэн ажилдаа үндэслэн, хэрэв энэ аудиторын тайланг гаргах өдрөөс өмнө бидний олж авсан бусад мэдээлэлд материаллаг хэмжээний буруу илэрхийлэл байгаа гэж дүгнэвэл бид үүнийг тайлагнах шаардлагатай. Энэ талаар бидэнд тайлагнах мэдээлэл байхгүй байна.



Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор засаглал хариуцсан эрх бүхий этгээд болон удирдлагын зүгээс хүлээх үүрэг хариуцлага

Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэж, бодитойгоор тайлагнах болон залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийллээс ангид нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангууд бэлтгэхэд шаардлагатай гэж удирдлага тодорхойлсон дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх нь удирдлагын үүрэг хариуцлага байна.

Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудыг бэлтгэх явцад удирдлага Групп болон Компанийн үйл ажиллагааг цаашид тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжийг үнэлэх, тухайн чадамжид нөлөөлөх нөхцөл байдлын талаар зохистой үед тодруулах болон Групп болон Компанийн үйл ажиллагааг татан буулгах, үйл ажиллагааг зогсоохор төлөвлөж байгаа эсвэл зогсохоос өөр сонголтгүй болсноос бусад тохиолдлуудад нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримтлах үүрэгтэй.

Групп болон Компанийн засаглал хариуцсан эрх бүхий этгээд нь санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго бол залилан эсвэл алдааны улмаас нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ материаллаг буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах мөн бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хэдийгээр үндэслэлтэй баталгаа нь өндөр түвшний баталгаа боловч, АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь материаллаг буруу илэрхийлэл байх тохиолдол бүрийг олж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх боломжтой ба энэ нь нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланг хэрэглэгчдийн эдгээр тайланд үндэслэн гаргах эдийн засгийн шийдвэрт тус бүрдээ эсвэл нийт дүнгээрээ нөлөөлөхүйц байвал материаллаг буруу илэрхийлэл болно.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах, мэргэжлийн холбогдох итгэл үнэмшил бүхий үнэлэлтүүдийг хийдэг. Мөн бид:

- Залилан болон алдааны улмаас нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг илрүүлэн үнэлэх, тэдгээр эрсдэлүүдэд нийцсэн аудитын горимыг тодорхойлон гүйцэтгэх, аудитын дүгнэлт гаргахад үндэслэл болох хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авдаг. Залилан нь нууцаар үгсэн тохирох, хуурамч бичиг баримт үйлдэх, санаатайгаар орхигдуулах, хуурамч батламж гаргах эсвэл эрх мэдлээ хэтрүүлэн дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотойгоор үүсдэг тул залилангаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас шалтгаалж үүсэх материаллаг буруу илэрхийллийг олж илрүүлэхгүй байх эрсдэлээс илүү өндөр байдаг.
- Групп болон Компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг тодорхойлох зорилгын хүрээнд дотоод хяналтын тогтолцооны ойлголтуудыг аудитын явцад олж авдаг.
- Удирдлагын зүгээс мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал болон хийсэн тооцооллуудын үндэслэлтэй байдал, холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Групп болон Компани нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадварт томоохон хэмжээний эргэлзээ үүсч болох нөхцөл байдал, тухайн үйл явдлуудтай холбоотойгоор материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэх болон удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүйгээр хангахад зөв зохистой нягтлан бодох бүртгэлийн суурийг сонгосон эсэхийг аудитын туршид бүрдүүлсэн нотолгоонд үндэслэн дүгнэдэг. Хэрэв үйл ажиллагаагаа тасралтгүйгээр үргэлжлүүлэх чадамжид материаллаг тодорхойгүй байдал оршин байгаа гэж үзсэн тохиолдолд нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудын холбогдох тодруулгыг аудиторын тайланд тусгах, анхааруулах мөн эдгээр тодруулгууд хангалтгүй гэж үзсэн тохиолдолд дүгнэлтээ өөрчилдөг. Бид дүгнэлтээ аудиторын тайланг гаргах өдрийг хүртэл олж авсан аудитын нотолгоонуудад үндэслэн гаргадаг боловч ирээдүйд болох үйл явдал, нөхцөл



Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

байдлуудаас шалтгаалан Групп болон Компанийн үйл ажиллагаа зогсох нөхцөл байдал үүсч болно.

- Тодруулгуудыг оролцуулан нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий агуулга болон бүтцийг бүхэлд нь үнэлдэг ба ач холбогдол бүхий ажил гүйлгээ, үйл явдлуудыг нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв тодруулах шаардлагыг хангахуйц байдлаар илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.
- Нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт гаргахын тулд Группийн доторх байгууллагууд болон бизнесийн үйл ажиллагаануудын санхүүгийн мэдээлэлтэй хамааралтай аудитын хангалттай бөгөөд зохистой нотолгоо олж авдаг. Бид групп аудитыг гүйцэтгэх болон нягтлан шалгах чиглэлээр хариуцлага хүлээдэг. Бид гаргасан аудитын дүгнэлтэндээ л зөвхөн хариуцлага хүлээнэ.

Бид засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд аудитын үйл ажиллагааны төлөвлөсөн цар хүрээ, аудит гүйцэтгэх цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн томоохон асуудлуудын талаар мэдээлдэг бөгөөд үүнд дотоод хяналтын дутагдалтай талууд мөн багтдаг.

Бид мөн хараат бус байдалд тавигдах ёс зүйн хэм хэмжээний тухай, хараат бус байдалд нөлөөлөх харилцаа болон бусад бүхий л нөлөөлөхүйц хүчин зүйлсийн талаар, шаардлагатай нөхцөл байдалд тэдгээрээс хараат бус байдлыг хэрхэн хамгаалах арга хандлагаа тусгасан мэдэгдлийг засаглал хариуцсан эрх бүхий этгээдэд гаргаж өгдөг.

Засаглал хариуцсан эрх бүхий этгээдтэй харилцсан зүйлсээсээ бид тухайн тайлант хугацааны нэгтгэсэн болон тусдаа санхүүгийн тайлангуудын аудитад хамгийн чухал нөлөөтэй зүйлсийг буюу аудитын гол асуудлыг тодорхойлдог. Эдгээр асуудлуудыг бид хууль тогтоомжоор олон нийтэд дэлгэхийг хориглосон эсвэл, маш цөөн тохиолдолд, уг асуудлуудыг мэдээлснээс үүсэх таагүй үр дагавар нь олон нийтийн эрх ашгаас илүү өндөр хэмээн үзсэнээс бусад тохиолдолд аудитын тайландаа тусгадаг.

Энэхүү хараат бус аудиторын тайланг гаргаж буй аудитын партнер нь Шаукат Тапия болно.

Гарын үсэг зурсан:



Дэваагийн Баярмаа

Гүйцэтгэх захирал

ПрайсотерхаусКуперс Аудит ХХК

Баталсан:

Шаукат Тапия


Партнер

ПрайсотерхаусКуперс Аудит ХХК


2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр



Холбоо барих:

 +976-77330101

 info@cumongol.mn, hr@cumongol.mn

 www.cumongol.mn